



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



## 3-17 НАСТАЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ

УЛААНБААТАР, 2023

## АГУУЛГА

.....	1
<b>БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН</b> .....	1
<b>ӨМНӨХ ҮГ</b> .....	3
<b>УДИРТГАЛ</b> .....	4
Монголын хүүхэд, залуучуудын бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн шалгуур, үзүүлэлт, түүний хэрэглээ .....	4
Зориулалт .....	5
Хэрэглээнд баримтлах шаардлага .....	5
<b>I. Сургуулийн өмнөх насны 3-5 настай хүүхдийн хөгжлийн шалгуур</b> .....	7
<b>Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдарын хөгжил (3-5 нас)</b> .....	7
<b>Биеийн ерөнхий хөгжил</b> .....	7
<b>Бие бялдарын бэлтгэлжилт</b> .....	8
<b>Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил (3-5 нас)</b> .....	10
<b>Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (3-5 нас)</b> .....	12
<b>II. Бага боловсролын 6-10 настай хүүхдийн хөгжлийн шалгуур</b> .....	14
<b>Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдарын хөгжил (6-10 нас)</b> .....	14
<b>Бие бялдарын бэлтгэлжилт</b> .....	16
<b>Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил (6-10 нас)</b> .....	18
<b>Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (6-10 нас)</b> .....	21
<b>III. Суурь боловсролын 11-14 настай хүүхдийн хөгжлийн шалгуур</b> .....	25
<b>Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдарын хөгжил (11-14 нас)</b> .....	25
<b>Бие бялдарын хөгжил</b> .....	25
<b>Бие бялдарын бэлтгэлжилт</b> .....	26
<b>Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил (11-14 нас)</b> .....	29
<b>Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (11-14 нас)</b> .....	30
<b>IV. Бүрэн дунд боловсролын 15-17 настай хүүхдийн хөгжлийн шалгуур</b> .....	32
<b>Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдарын хөгжил (15-17 нас)</b> .....	32
<b>Бие бялдарын хөгжил</b> .....	32
<b>Бие бялдарын бэлтгэлжилт</b> .....	33
<b>Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил (15-17 нас)</b> .....	35
<b>Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (15-17 нас)</b> .....	37

Хүүхэд, залуучуудын хөгжлийн онцлогийг тусгасан, түүнийг харгалзан үзсэн сургалт, хөгжлийн үйл ажиллагаа, харилцаа нь аль ч улс орны боловсролын салбарынхны нэн тэргүүний зорилт байдаг. Үүнтэй холбоотойгоор хүүхэд, залуучуудын хөгжлийн стандартыг насны үе шат эсвэл боловсролын түвшинд баримжаалан боловсруулж, даган мөрддөг дэлхийн улс орнуудын туршлага байна.

Монгол улсын Засгийн Газрын 2010 оны 173 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын шинжлэх ухаан технологийг хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэл 2010-2014 он”-ы тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх цөм технологийн жагсаалтад “Хүний хөгжил, төлөвшил, боловсролын шинэчлэлийн технологи”-ийг “Хүний хөгжил, амьдралын чанар тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд багтаасан. Үүнтэй холбоотой 2014-2018 онд хүүхэд, залуучуудын хөгжлийн цогц судалгааг цөм технологи бий болгох зорилгоор хэрэгжүүлсэн 21 нас хүртэлх монгол хүүхэд, залуучуудын цогц хөгжлийн судалгааны үр дүнд тулгуурлан хөгжлийн шалгуур үзүүлэлтийг боловсролын түвшинд баримжаалан боловсруулсан бол 2 дахь шатны судалгааг 2019-2021 онд явуулж, судалгааны харьцуулсан үр дүнд тулгуурлан 3-17 хүртэлх насны хүүхдийн цогц хөгжлийн шалгуур, үзүүлэлтийг боловсрууллаа.

Хүүхэд, залуучуудын хөгжлийн шалгуур үзүүлэлтийг шат шатны боловсролын мэргэжилтнүүд, бодлого боловсруулах, холбогдох баримт бичиг боловсруулах болон бодлогыг хэрэгжүүлэхдээ ашиглах улмаар багш, ажилтнууд, эцэг, эхчүүд, хүүхэдтэй ажилладаг хүн бүр төдийгүй хүүхэд залуучууд өөрсдөө хөгжлийн онцлогоо танин мэдэх, дэмжих үйл ажиллагаанд хэрэглэх бүрэн боломжтой юм.

Шалгуур үзүүлэлтийн агуулга нь сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшний 3-17 настай хүүхдийн бие бялдар, танин мэдэхүйн хөгжил, нийгэмшлийн чадваруудын дундаж үзүүлэлт, хамгийн бага болон хамгийн өндөр түвшинг тусгаснаас гадан чадвар бүрээр дэмжих үйлийг санал болгов.

Энэхүү шалгуур үзүүлэлтийг боловсруулахад хамтран ажилласан доктор О.Мягмар, П.Цэрэндондов, Ж.Батдэлгэр, Б.Туяа, Б.Мөнгөнцэцэг, Ж.Баянсан, Л.Уртнасан, Л.Гүндэгмаа; болон Сэтгэл судлалын үндэсний төвийн гүйцэтгэх захирал Б.Ууганцэцэг нартаа гүн талархал илэрхийлье.

*Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Хүний хөгжлийн судалгааны сектор*

## УДИРТГАЛ

3-17 настай хүүхдийн хөгжлийн шалгуур, үзүүлэлтийг “Монгол хүүхдийн цогц хөгжлийн онцлог” төслийн судалгааны хүрээнд үндэсний хэмжээнд хийгдсэн судалгааны үр дүнд тулгуурлан боловсруулав. Шалгуур, үзүүлэлт нь бие бялдар, танин мэдэхүйн хөгжил, нийгэмшлийн чадваруудын дундаж үзүүлэлтэд үндэслэсэн.

Бие бялдрын шалгуур үзүүлэлт нь бие бялдрын хөгжил, бэлтгэлжилт гэсэн хөгжлийн дэд хэсэгтэй. Харин танин мэдэхүйн хөгжлийн шалгуур үзүүлэлт нь мэдээллийг хүртэж хүлээж авах, боловсруулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадвар ба хэл ярианы чадваруудаас бүрдсэн.

Нийгэмшлийн шалгуур үзүүлэлт нь өөртөө хандах хандлага, зан төлөв, сэтгэлийн хөдөлгөөн, харилцаа, эзэнгшилт, дасан зохицолт, үнэт зүйл, нийгмийн хэм хэмжээ гэсэн дэд бүрдлүүдээс бүрдэнэ.

*Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд хамрагдах насны 3-17 настай хүүхдийн хөгжлийг:*

- Бие бялдар, танин мэдэхүйн хөгжлийн хүрсэн байх доод хязгаар, түүний бодит илрэл;
- Нийгэмшлийн ерөнхий онцлогийг өөртөө хандах хандлага, зан төлөв, сэтгэлийн хөдөлгөөн, харилцаа, үнэт зүйл, нийгмийн хэм хэмжээний хүрээний илрэлийн ерөнхий шинжээр нь авч үзэв.

Бид “хүүхэд” гэсэн бүлэгт 3-5 настай сургуулийн өмнөх насны хүүхэд, 6-10 настай бага ангийн сурагчид, 11-14 настай дунд ангийн сурагчид, 15-17 настай ахлах ангийн сурагчдыг хамруулав.

### **Монголын хүүхэд, залуучуудын бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн шалгуур, үзүүлэлт, хэрэглээ**

3-17 настай хүүхдийн хөгжлийн шалгуур, үзүүлэлт нь тэдний бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн онцлог шинж, чадваруудыг боловсролын түвшингээр илэрхийлсэн баримт бичиг юм. Энэхүү баримт бичиг нь сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд хамрагдах насны хүүхэд бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн чадварын хувьд хамгийн наад зах нь ямар шаардлага, шинжийг хангахыг зааж өгсөн. Тухайн боловсролын түвшин тус бүрд хамрагдах насны хүүхэд, залуучууд бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн чадамжийн хүрээнд ямар чадваруудтай байх буюу юу чаддаг байх нь зохимжтой байх нь баримт бичгийн гол агуулга юм.

**Зорилго:** Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролд хамрагдах насны хүүхдийн хөгжлийн (*бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшил*) хүрэх түвшин, хэмжих үзүүлэлтүүдийг тодорхойлоход оршино.

#### **Зорилт:**

- Бодлого боловсруулагчид тодорхой түвшинд хамаарах бодлогын баримт бичиг боловсруулах, хөгжлийн хөтөлбөр боловсруулахад хамаарах насны хүүхдийн хөгжлийн онцлогийг тооцох,

- Боловсролын үндэсний байгууллагын хувьд үндэсний хөтөлбөр боловсруулах, сурах бичиг, сургалтын төлөвлөгөө боловсруулахад, багшийн мэргэжил дээшлүүлэхэд агуулга аргагүйтэй холбоотой шийдвэр гаргахад тухайн насны хүүхдийн хөгжлийн онцлогийг тооцох,
- Сургалт эрхэлж буй боловсролын байгууллагын хувьд хичээлийн хөтөлбөр, аргагүй, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хичээлээс гадуурх үйл ажиллагааны агуулга, арга хэлбэр, зохион байгуулалт болон сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг хүүхдийн насны онцлогт нийцүүлэхэд, гэр бүл, эцэг, эхчүүдэд чиглэсэн үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөр боловсруулах ашиглах,
- Эцэг эх, асран хамгаалагчдын хувьд хүүхдийн хөгжлийн талаар шинжлэх ухааны үндэстэй баримжаатай болох, онцлогийг мэдэх улмаар хүүхдийнхээ хөгжлийг дэмжсэн амьдралын орчин, нөхцөл, харилцааг бүрдүүлэх,
- Хүүхдийн хувьд өөрийн хөгжлийн талаар ойлголттой болж, хөгжлийг зорилго чиглэлтэйгээр удирдах болно.

### **Онцлог нь:**

- 3-17 насны бүлэг бүрээр хүрэх түвшин, үзүүлэлтийг тусгасан.
- Шалгуур, үзүүлэлтийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн судалгаанд үндэслэн боловсруулсан.

### **Зориулалт**

Шалгуур, үзүүлэлтийг хүүхэдтэй холбоотой ажил эрхэлж байгаа болон тэдэнтэй холбогдох бүхий л байгууллага, иргэн, хувь хүн өөрсдийн эрхэлдэг ажлын онцлог, зорилготой уялдуулан ашиглана. Боловсролын салбарын холбогдох мэргэжилтэн, иргэдийн хувьд дараах чиглэлээр ашиглах боломжтой. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах 3-5 насны хүүхдийн хөгжлийн онцлог, хүрэх түвшин, хэмжих үзүүлэлт тодорхой болно. Сургуулийн өмнөх боловсролын бодлогын үндэслэл болохоос гадна боловсролын байгууллагын багш ажилтан, эцэг, эхчүүд, асран хамгаалагчдад хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэл болно.
- Бага боловсролд хамрагдах 6-10 насны хүүхдийн хөгжлийн онцлог, хүрэх түвшин, хэмжих үзүүлэлт тодорхой болно. Бага боловсролын бодлогын үндэслэл болохоос гадна боловсролын байгууллагын багш ажилтан, эцэг, эхчүүд, асран хамгаалагчдад хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэл болно.
- Суурь боловсролд хамрагдах 11-14 насны хүүхдийн хөгжлийн онцлог, хүрэх түвшин, хэмжих үзүүлэлт тодорхой болно. Суурь боловсролын бодлогын үндэслэл болохоос гадна боловсролын байгууллагын багш ажилтан, эцэг, эхчүүд, асран хамгаалагчдад хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэл болно.
- Бүрэн дунд боловсролд хамрагдах 15-17 насны хүүхэд, залуучуудын хөгжлийн онцлог, хүрэх түвшин, хэмжих үзүүлэлт тодорхой болно. Бүрэн дунд боловсролын бодлогын үндэслэл болохоос гадна боловсролын байгууллагын багш ажилтан, эцэг, эхчүүд, асран хамгаалагчдад хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих мөн тэд өөрийн хөгжлийг баримжаалан удирдахад чиглэл болно.

### **Шалгуур, үзүүлэлтийг хэрэглэхдээ баримтлах зарчим**

- *Хувийн онцлог шинж.* – Хүүхдийн хувийн давтагдашгүй өвөрмөц онцлогийг таних, ойлгох, хүндэтгэлтэй хандан, хүлээн зөвшөөрөх
- *Тэгш байх.* Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролд хамрагдах насны бүх хүүхдэд тэгш үйлчилнэ. Үндэс, угсаа, нийгмийн гарал, байр сууриас хамаарсан ялгаатай байдал байхгүй
- *Нийцтэй байх.* Хөгжлийг шалгуур, үзүүлэлтийн хэмжигдэхүйц хүрээнд баримжаална. Хүүхдийн хөгжлийн түвшин, онцлогийг үнэлэх, харьцуулахдаа шалгуур, үзүүлэлтэд баримжаална. Өөр бусад тохиолдолд стандарт үндэслэл болохгүй.

- *Зорилгод баримжаалах*-Хүүхдийн хөгжлийг үнэлэх, дэмжих бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн стандартын хэрэглээ янз бүр байж болно.
- *Хөгжлийг дэмжих*-Хүний хөгжил, үйл ажиллагааны чанар үр дүнг шууд үнэлэх үнэлгээний болон урамшуулал, сануулга гэх мэт арга хэмжээний хэрэгсэл болохгүй. Энэ нь зөвхөн хүүхдийн хөгжлийг бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хүрээнд дэмжих чиглэлийн үүрэгтэй.
- *Хамтын ажиллагаанд тулгуурлах*- Гэр бүл, шат шатны боловсролын ба сургалтын байгууллагын хамтын ажиллагааны нэгдэлд тулгуурлана.
- *Идэвхтэй оролцоонд тулгуурлах*-Хөгжлийг дэмжихэд чиглэсэн аливаа бодлого, баримт бичиг, харилцаа, үйл ажиллагаа нь хүүхдийн бие даасан үйл ажиллагаагаар хэрэгжих бөгөөд “*өөрөө үйлдэх замаар сурч хөгжинө*” гэдэгт баримжаалах нь зүйтэй.

# I. СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ 3-5 НАСТАЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ШАЛГУУР

## Хөгжлийн ерөнхий онцлог нь:

**Бие бялдрын хөгжил:** Биеийн том булчингийн хөгжил эрчимтэй хөгждөгтэй холбоотой үсрэх, харайх, гүйх, биеийн тэнцвэрээ олох, дасгал хөдөлгөөн хийх, бүжиглэх чадвартай.

**Танин мэдэхүйн хөгжил:** Юмстай үйлдэл хийх, харах замаар суралцдаг, сонирхолтой, таатай зүйлдээ анхаарал хандуулдаг, анхаарал нь хялбар сарнидаг, мэдээллийг цээжлэх замаар тогтооно, бодит зүйлийг хийсвэр зүйлээс ялгахгүй байх нь бий. Зурах, бүтээх сонирхолтой болно.

**Нийгэмшлийн онцлог:** Бусадтай хамт тоглох, харилцах дуртай болно. Сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмжээ илэрхийлнэ. Дүрэм, зааврыг ойлгож дагах чадвартай.

## Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдрын хөгжил (3-5 нас)

### Биеийн ерөнхий хөгжил

Биеийн жин (кг)						
Хөвгүүдийн биеийн жин 3-4 насанд 1.4 кг, 4-5 насанд 2.6 кг-аар; охидын биеийн жин 3-4 насанд 1.5 кг, 4-5 насанд 1.9 кг-аар нэмэгдсэн.						
Түвшин	Хөвгүүд			Охид		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Дээд	19.58	20.74	24.79	19.1	20.57	23.14
Дунджаас дээгүүр	17.64	18.75	21.68	16.85	18.23	20.41
Дундаж	16.26	17.8	20.28	15.92	17.24	19.17
Дунджаас доогуур	15.11	16.86	18.79	14.46	16.22	17.89
Доод	13.56	15.15	16.83	12.65	14.8	15.91

Биеийн өндөр (см)						
Охидын биеийн өндөр 3-4 насанд 6.1 см, 4-5 насанд 6.6 см; хөвгүүд 3-4 насанд 5.5 см, 4-5 насанд 7 см-ээр өссөн байна.						
Түвшин	Хөвгүүд			Охид		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Дээд	108.75	112.35	120.02	106.56	111.94	118.7
Дунджаас дээгүүр	103.91	108.77	116.48	102	107.85	114.86
Дундаж	100.91	106.45	113.55	99.53	105.55	112.17
Дунджаас доогуур	98.19	104.27	111.09	96.94	103.7	110.03
Доод	94.77	100.31	106.6	92.21	99.7	106.23

Толгойн тойрог (см)						
Нас нэмэгдэх тусам 0.5 см-0.6 см-ээр нэмэгдсэн байна. Хүүхдийн тархины хэмжээ 5 насанд хүрэхэд жингийн хувьд насанд хүрсэн хүнийхтэй бараг тэнцүү болж тархины мушгиралт ба ховилын хөгжил маш эрчимтэй явагддаг байна.						
Түвшин	Хөвгүүд			Охид		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Дээд	108.75	112.35	120.02	106.56	111.94	118.7
Дунджаас дээгүүр	103.91	108.77	116.48	102	107.85	114.86
Дундаж	100.91	106.45	113.55	99.53	105.55	112.17
Дунджаас доогуур	98.19	104.27	111.09	96.94	103.7	110.03
Доод	94.77	100.31	106.6	92.21	99.7	106.23

Дээд	52.68	53.09	53.52	52.32	52.43	53.28
Дунджаас дээгүүр	51.51	51.95	52.44	50.94	51.09	51.94
Дундаж	50.95	51.08	51.99	49.95	50.61	51.01
Дунджаас доогуур	49.95	50.55	51.13	48.99	49.92	50.12
Доод	48.63	49.68	49.82	47.32	48.24	48.69

#### Цээжний тойрог (см)

Цээжний тойрог нь хөвгүүдийн хувьд 3-4 насанд 1.4 см, 4-5 насанд 1.7 см; охидын хувьд 3-4 насанд 1.1 см, 4-5 насанд 1.7 см-ээр нэмэгддэг байна.

Түвшин	Хөвгүүд			Охид		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Дээд	57.9	58.99	62.14	57.07	58.25	60.68
Дунджаас дээгүүр	55.51	56.96	58.97	54.81	55.93	57.54
Дундаж	54.07	55.6	57.45	53.5	54.41	55.98
Дунджаас доогуур	52.92	53.98	55.47	52.06	53.04	54.38
Доод	51.25	52.08	52.73	49.69	51.05	52.3

#### Бүсэлхийн тойрог (см)

Бүсэлхийн тойрог хөвгүүдийн хувьд 3-4 насанд 0.7см, 4-5 насанд 1.5 см-ээр, охидын хувьд нэмэгдэх тусам өссөн 3-4 насанд 1.2 см, 4-5 насанд 0.4 см -ээр нэмэгддэг байна.

Түвшин	Хөвгүүд			Охид		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Дээд	56.47	56.36	60.43	55.6	57.11	58.42
Дунджаас дээгүүр	53.42	54.05	55.81	52.58	53.89	54.52
Дундаж	51.53	52.46	53.44	51.08	52.38	52.67
Дунджаас доогуур	49.96	50.45	51.58	49.47	50.55	50.63
Доод	48.02	48.04	48.81	45.76	48.03	47.87

#### Бие бялдрын чадварыг дэмжих үйл

- Том булчингийн хөдөлгөөнийг дэмжихдээ гүйх, харайх, үсрэх, шатаар авирах, усанд сэлэх гэх мэт үйлийг аль болох хийлгэх. Ингэхдээ гэрийн нөхцөлд, сургалтын явцад эдгээр үйлийг хэрхэн ямар цагт, ямар давтамжтай хийлгэхээ эцэг эх асран хамгаалагчид, багш нар тооцох хэрэгтэй.
- Жижиг булчингийн хөдөлгөөнийг дэмжихдээ товч товчлох, үдээс үдэх, шүр хэлхэх, зураг будах гэх мэт үйлдлүүдийг аль болох өдөр бүр хийлгэх
- Хүүхдийг тогтмол 20-21 цагийн хооронд унтах дадал сургах

#### Бие бялдрын бэлтгэлжилт

**Хурд - 50м гүйлт (сек) босоо гараанаас 30- 50 м зайд гүйсэн хугацааг хэмжинэ.**

Хөвгүүдийн богино зайг хурдтай туулах чадвар нас нэмэгдэх тусам 0.6 секундээс 0.3 секундээр, охидын хувьд 0.6 секундээс -0.5 секундээр туулах чадвар сайжирдаг байна.

Түвшин	Хөвгүүд			Охид		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Дээд	3.28	2.89	2.58	3.49	3.01	2.8
Дунджаас дээгүүр	3.77	3.33	2.99	3.98	3.46	3.18
Дундаж	4.22	3.62	3.32	4.44	3.87	3.48



Дунджаас доогуур	4.69	4.06	3.68	4.93	4.33	3.87
Доод	5.94	5.09	4.97	6.84	6.35	5.11

**Уян хатан: (см) Хөлөө жийж суусан байдлаас бөхийж, гарын хурууг өлмийнөөс цааш гаргасан зайг хэмжинэ.**

Хөдөлгөөний үйлдлийг хамгийн их далайцаар гүйцэтгэх буюу уян хатны үзүүлэлт 3-5 насанд тогтвортой хөвгүүдийн үзүүлэлт 6.7 см, охидын үзүүлэлт 7.6 см дунджаар байдаг байна.

Түвшин	Хөвгүүд			Охид		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Дээд	12.08	13.5	11.76	13.85	14.1	14.13
Дунджаас дээгүүр	8.37	9.11	8.33	9.54	9.4	10.05
Дундаж	6.56	6.65	6.5	7.43	7.51	7.58
Дунджаас доогуур	4.38	4.46	4.23	5.61	5.06	5.39
Доод	1.34	1.77	0.51	3.18	1.85	2.42

**Тэнцвэр: (сек) Нэг хөл дээрээ тэнцвэрээ олж зогсох хугацаагаар хэмжинэ.**

Хүүхдүүдийн тэнцвэрийн чадвар 3-4 насанд хөвгүүдийн хувьд 3.4 сек, 4-5 насанд 7.1 сек; охид 3-4 насанд 5.3 сек, 4-5 насанд 7.6 секундээр сайжирсан байна.

Түвшин	Хөвгүүд			Охид		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Дээд	22.54	28.55	43.69	36.37	44.46	63.25
Дунджаас дээгүүр	10.25	15.25	25.42	13.83	20.32	32.06
Дундаж	5.94	9.81	17.4	7.56	13.2	19.83
Дунджаас доогуур	2.37	4.49	7.84	2.35	4.92	6.92
Доод	0.0	1.09	2.07	0.0	1.22	1.32

**Хөлийн хүч: (см) Байрнаас уртад харайлт**

**(Байрнаас хоёр хөлөөр түлхэн уртад харайсан зайг хэмжинэ. 3 удаагийн харайлтын хамгийн холыг тооцно.)**

Хөлийн тэсрэлтийн хүчний хувьд хөвгүүд 3-4 насанд 24.3 см, охидын хувьд 3-4 насанд 20.8 см, 4-5 насанд 5.3 см нэмэгдсэн ба нас нэмэгдэх тусам хөлийн хүч сайжирч байна.

Түвшин	Хөвгүүд			Охид		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Дээд	83.63	102.73	121.17	76.92	93.69	104.16
Дунджаас дээгүүр	65.54	88.62	102.96	59.34	78.86	91.30
Дундаж	55.65	77.31	91.0	50.16	68.06	81.59
Дунджаас доогуур	45.94	64.9	79.09	39.3	58.74	70.99
Доод	31.29	43.19	56.43	25.16	40.61	47.06

**Тэсвэр: (сек) Насны онцлогоос хамаарч зөвхөн 4-5 насны хүүхдүүдээр 200м гүйлгэж хугацаагаар хэмжинэ.**

Тэсвэрийн үзүүлэлтийг насны онцлогийн дагуу 3 насны хүүхдүүдээс аваагүй. Хүүхдүүдийн тэсвэрийн чанар нас нэмэгдэх тусам 0.10 секундээр сайжирсан байна.

Түвшин	Хөвгүүд		Охид	
	4 нас	5 нас	4 нас	5 нас
Дээд	53.0	40.27	55.71	45.11
Дунджаас дээгүүр	68.26	56.71	68.61	58.39

Дундаж	78.2	67.26	78.01	66.41
Дунджаас доогуур	92.53	83.18	90.41	79.15
Доод	143.15	188.7	115.79	154.52

### Бие бялдрын чадварыг дэмжих үйл

- Хөдөлгөөн тэнцвэрийн чадварыг дэмжихдээ нэг хөл дээрээ зогсох, үсрэх, бөмбөг дамжуулах, бөмбөг хана руу шидэж барих, бай онох, сагсны цагираг, сав/хайрцагт бөмбөгийг тодорхой зайнаас шидэж оруулах зэрэг үйлдлүүдийг хийлгэх. Ингэхдээ хүүхдийн гүйцэтгэх чадварыг ажиглаж тухайн үйлийг хэр бүрэн гүйцэтгэж буйд анхаарал хандуулна. Тухайлбал, нэг хөл дээрээ зогсож тэнцвэрийн чадвараа хөгжүүлэх дасгал хийлгэхдээ чанга тоолж, өдөр өдрөөр тоолох хурдаа багасгах эсвэл тоог нэмэгдүүлж, хүүхдийг чадварт гарч буй ахицыг дурьдаж урамшуулах маш чухал.
- Бүжиг, гимнастикийн дасгал хөдөлгөөнийг бүжгийн аянд хийлгэх. Хэрэв хүүхдээ дугуйланд явуулах боломжгүй бол гэртээ хөгжим тавьж, хамтдаа бүжиглэх, тоот дасгалыг хамтдаа хийж болно. Ингэхдээ хүүхэд замраагүй хөдөлгөөн хийхээс сэргийлж хүүхдийн насанд тохирсон цахим бичлэгийг тавьж дуурайн хийлгэх, эсвэл эцэг эх асран хамгаалагчид тухайн насны хүүхэд ямар хөдөлгөөн хийх хичээлүүдийг олж судлан, өөрөө үлгэрлэн хүүхдээ хийлгэх хэрэгтэй. Хөдөлгөөн гэдэг өөрийн техниктэй үйл явц гэдгийг багш, эцэг эх асран хамгаалагчид мартаж болохгүй.

### Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил (3-5 нас)

Хүртэхүй				
Шалгуур	Үзүүлэлт			Чадварыг дэмжих үйл
	3 нас	4 нас	5 нас	
<b>Ажиглан хүртэх чадвар</b>	Энгийн хялбар танил юмсын ижил болон ялгаатай 1 шинжийг ажиглан таньдаг болно.	Энгийн хялбар, танил юмсын 1-2 ижил төстэй болон ялгаатай шинжийг таньж нэрлэдэг болно. Өмнөх настай харьцуулахад хурдан танина.	Энгийн хялбар танил юмсын 3 ба түүнээс дээш ижил төстэй, ялгаатай шинжийг нь хялбархан ажиглан хүртэж нэрлэдэг болно.	Юмсын ижил төстэй ба ялгаатай шинжийг хүүхдээр ажиглуулах нэрлүүлэх;
Анхаарал				
Шалгуур	Үзүүлэлт			Чадварыг дэмжих үйл
	3 нас	4 нас	5 нас	
<b>Анхаарлаа төвлөрүүлэх чадвар</b>	Өөрийн сонирхол татсан зүйлд илүү анхаарлаа хандуулдаг. Анхаарал нь хялбар сарнина.	Анхаарлаа төвлөрүүлэн үйлдэл гүйцэтгэх чадвар сайжирна. Тухайлбал, зураг, дүрс зурах, бичих гэх мэт.	Зааврыг ойлгон анхаарлаа төвлөрүүлэн үйлдлийг гүйцэтгэх чадвартай болно.	Зурах, бичих, тоо тоолох, бусад бүтээх үйлд хүүхдийн анхаарлыг төвлөрүүлэх үйлдлийг тогтмол хийлгэх. Ялангуяа, 4 наснаас хүүхэд зурах, будах, бичих гэх мэт үйлдлийг хийх;
Ой тогтоолт				
Шалгуур	Үзүүлэлт			Чадварыг дэмжих үйл
	3 нас	4 нас	5 нас	

<b>Мэдээлийг тогтоох чадвар</b>	Энгийн дүрс зургийг хараад 4-6 хүртэлхийг богино хугацаанд тогтоож сэргээн санана.			Зураг харж тогтоох үйлийг хийх 3-4 насанд 3-4 зураг, 5 насанд 5-7 хүртэлхийг тогтоох үйлийг хийх;
	Танил үгсийг сонсоод 2-3 хүртэлхийг тогтоож сэргээн санана.	Танил үгсийг сонсоод 3-4 хүртэлхийг тогтоож сэргээн санана.	Танил үгсийг сонсоод 4-6 хүртэлхийг тогтоож сэргээн санана.	Богино хэмжээний үлгэр шүлэг, үгийг тогтоолгох, үйл явдлыг нь яриулах;
<b>Сэтгэхүй</b>				
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>			<b>Чадварыг дэмжих үйл</b>
	<b>3 нас</b>	<b>4 нас</b>	<b>5 нас</b>	
<b>Бодит дүрслэлийн сэтгэхүйн чадвар</b>	Бодитоор юмсыг харж, үйлдэл хийж ойлгох чадвар сул.	4 насанд дүрс зургийг таньж дуурайлгаж цэвэр зурах чадвартай болно. 5 насанд илт сайжирна.	5 насанд дүрс зургийг таньж дуурайлгаж цэвэр зурах чадвар илт сайжирна.	Дүрс зургийг дуурайлгаж зурах, зурааснаас гарахгүй будах, ялангуяа 4 наснаас янз бүрийн дүрс зургийг нэмэх хасах гэх мэт нарийн тэмдэглэгээ харж дуурайж тэмдэглэх, тоо бичих, үсэг бичих гэх мэт үйлдлийг хурдан хугацаанд хийх;
<b>Сэтгэхүйн ангилах, нэгтгэх чадвар</b>		Юмсын ижил төстэй ба ялгаатай нэг шинжийг таньж ерөнхий бүлэгт нэгтгэх, тухайлбал, цамц, өмд, хүрмийг бүгдийг нь өмсдөг зүйл, хувцас, хүнсний ногоонуудыг хоолонд хийдэг зүйл гэх мэтээр ялгаж нэгтгэнэ.	Янз бүрийн дүрсийг хараад хичээлд үздэг зүйл, хэлбэр гэх мэтээр ерөнхийлөн нэгтгэж сэтгэнэ.  Энгийн үзэгдэл юмсын талаарх ойлголт төсөөлөлтэй болно. Жишээлбэл, загас усанд амьдардаг, чоно ойд байдаг, зун дулаан улирал, бороо орно гэх мэтээр мэдлэг ойлголттой болно.	Юмсыг хэлбэр, хэмжээ эсвэл төрөл зүйлээр нь ангилан нэгтгэж нэг бүлэг болгон ерөнхийд нь нэрлүүлэх үйлдлийг хийх; Байгаль нийгмийн энгийн юмс үзэгдлийн тухай ойлголт төсөөлөл эзэмшихэд нь дэмжих; (жишээлбэл, хүн нисэх боломжгүй, шүхэр бариад өндрөөс үсрэх нь зохиомол зүйл, амьтан ярих боломжгүй талаарх ойлголт өгөх нь юмсын учир шалтгааны сэтгэхүй хөгжихөд дэмжлэг үзүүлнэ);
<b>Хэл яриа</b>				
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>			<b>Чадварыг дэмжих үйл</b>
	<b>3 нас</b>	<b>4 нас</b>	<b>5 нас</b>	
<b>Ярих чадвар</b>	Санаа бодлоо 3-4 богино өгүүлбэрээр илэрхийлдэг болно. 4 наснаас асуусан асуултад хариулах, харилцан ярилцах чадвар сайжирна.		Ярих чадвар эрс сайжирч өгүүлбэрийн тоо нэмэгдэнэ. Асуусан асуултыг сайн ойлгож хариулна.	Хүүхэдтэй ярилцах, асуулт асуух, асуултад нь хариулах, өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэхийг

			дэмжих, үлгэр, үзсэн зүйлийг нь яриулах;
--	--	--	--

### Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (3-5 нас)

<b>Өөртөө хандах хандлага</b>				
Шалгуур	Үзүүлэлт			Чадварыг дэмжих үйл
	3 нас	4 нас	5 нас	
<b>Өөрийн тухай ойлголт</b>	<p><u>“Өөрийг нь дууддаг”</u> нэрээ хэлнэ, заримдаа бүтэн нэрээ хэлнэ. Хүйсээ мэддэг болно. Насаа ихэнх нь хуруугаараа илэрхийлнэ. Аав ээжийнхээ нэрийг хагасалж хэлдэг болно.</p>	<p>- Ихэнх нь бүтэн нэрээ хэлнэ, зарим нь дууддаг нэрээ хэлнэ. - Өөрийн хүйсийг мэддэг болно. -Насаа хэлнэ, зарим тохиолдолд хуруугаараа илэрхийлэх нь бий. - Аав, ээжийнхээ бүтэн нэрийг хэлдэг болно, цөөн тохиолдолд хагасалж хэлнэ.</p>	<p>Бүтэн нэрээ хэлнэ. Өөрийн нэр, хүйсийг сайн мэднэ, илэрхийлнэ. Аав, ээжийнхээ нэрийг бүтнээр хэлнэ. Ам бүлийн тоо, цэцэрлэгийн бүлгээ сайн мэднэ, хэлнэ.</p>	<p>Өөрийн нас, нэр, хүйс, аав ээжийнхээ нэр, гэр бүлийнхээ гишүүдийн нэр, нас, хүйс, цэцэрлэгийн бүлгийг илэрхийлэх чадвартай болгох; хүүхэдтэй харилцан ярилцдаг байх;</p>
<b>Сэтгэлийн хөдөлгөөн</b>				
<b>Сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар</b>	<p>Баярлах, гомдох талаарх ойлголттой болно. Бусдын царай төрх, дохио зангааг хараад тэр бүр сэтгэлийн хөдөлгөөний тодорхой илрэлийг таних нь сул байж болно.</p>	<p>Өөрийгөө ямар тохиолдолд баярлаж, гомддог талаар ихэнх тохиолдолд мэдэж илэрхийлдэг болно. Бусдын царай төрх, дохио зангааг хараад сэтгэлийн хөдөлгөөний баярлах, уурлах, гайхах мэт илрэлийг таних чадвартай.</p>	<p>Өөрийн сэтгэл хөдлөлийн талаарх ойлголт нь сайжирч, сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг тодорхой нөхцөл байдалтай холбон илэрхийлэх чадвартай болно. Бусдын царай, төрх, дохио зангааг хараад сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг таних чадвар сайжирдаг.</p>	<p>Өөрийнх нь болон бусдын сэтгэлийн хөдөлгөөний илрэлийн талаар ярилцах, өөрт нь юу таалагддаг, юу тааламжгүй санагддаг, ямар үед баярладаг, ямар үед уур нь хүрдэг, тухайн үедээ ямар үйлдлээр илэрхийлдэг, ээж аав нь баярласан, гомдсоныг хэрхэн мэддэг гэх мэтээр ярилцах; Мөн сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг дуурайлгах; зураг харуулж яриулах; хүүхэдтэй харилцахдаа сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг нүүр царай, дохио зангаагаар тод илэрхийлдэг байх гэх мэт;</p>
<b>Харилцаа</b>				

<p><b>Бусадтай хамтрах чадвар</b></p>	<p>Бусадтай хамт тоглох, ямар нэгэн зүйлийг хамтдаа хийх дуртай болно. 4 наснаас тухайн чадвар сайжирч тоглоомоо өгч хүүхэдтэй тоглох, Өөрийн зүйлээ бусадтай хуваалцах чадвартай болно. Тэд өөрийн найзтай болно.</p>	<p>Бусадтай хамт тоглох, хамтдаа бүтээх, бусадтай өөрийн зүйлээ хуваалцах чадварыг дэмжих; Хүндлэх мэндлэх зан үйлийг эзэмшүүлэх</p>
<p><b>Бусдаас тусламж дэмжлэг авах чадвар</b></p>	<p>Зайлшгүй шаардлагатай үед хэнээс тусламж дэмжлэг авахаа мэддэг болно. 3 настай хүүхэд ээж аав, ах, эгчээсээ тусламж авна гэдгийг мэддэг болно. 4 насанд тухайн чадвар сайжирч бусад хүмүүсээс (жишээлбэл, багшаас, хажууд байгаа хүнээс, эмчээс гэх мэт) тусламж дэмжлэг авах талаар ойлголттой болно.</p>	<p>Хүүхэд хэзээ хэрхэн бусдаас дэмжлэг тусламж авах талаар ойлголт өгөх; Айдаст оруулсан ойлголт өгөхөөс зайлсхийх (жишээлбэл, эмчид хэлж тариулна, багшид нь хэлж загнуулна гэх мэт);</p>
<p><b>Хэм хэмжээг дагах чадвар</b></p>	<p>Хогийг хогийн саванд хаях, гарцаар, ногоон гэрэл асахад гарах, олон нийтийн газар ээж аавынхаа зааврыг дагах, орой шүдээ угаах, гараа зөв угаах талаар чадвартай болно.</p>	<p>Хэм хэмжээг дагах талаар насанд хүрэгчид гэр бүл, олон нийтийн газар өөрсдөө үлгэр дуурайл үзүүлэх, тайлбарлаж ойлгуулах;</p>

## II. БАГА БОЛОВСРОЛЫН 6-10 НАСТАЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ШАЛГУУР

### Хөгжлийн ерөнхий онцлог

**Бие бялдрын хөгжил:** Өөрийн биеийн үйлдэл хөдөлгөөнөө хянах зохицуулах чадвар сайжирна. Биеийн булчингийн хүч нэмэгддэг.

Монголын хүүхдийн бялдрын хөгжлийн шалгуурын үндсэн үзүүлэлт болох, биеийн өндөр, биеийн жин үзүүлэлтүүдийг нас хүйс тус бүрээр дундаж түвшин, дундаас дээгүүр буюу дундаас доогуур, мөн дээгүүр ба доогуур гэсэн 5 түвшинтэй шалгуурын ДЭМБ-аас практикт өргөн хэрэглэдэг прецентилийн аргаар Statistica Softwear 8 программ дээр боловсруулан гаргалаа. Тухайлбал, 6 настай эмэгтэй хүүхдийн биеийн өндрийн дундаж үзүүлэлт 112.4 - 118.9 см байх бөгөөд 109.75 см хүртэлх үзүүлэлттэй бол дунджаас доогуур, түүнээс доош бол доогуур өсөлтийн түвшинтэй буюу намхан хүүхэд гэж үзнэ. Харин 6 настай дундаж түвшнээс 121.9 см хүртэлх нь дундаас дээгүүр буюу түүнээс дээш үзүүлэлттэй бол дээгүүр үзүүлэлт буюу өндөр хүүхэд гэж үзнэ.

7 насанд эмэгтэй хүүхдийн биеийн өндрийн дундаж үзүүлэлт 117.1 – 123.9 см байх бөгөөд 112.6 см хүртэлх үзүүлэлттэй бол дунджаас доогуур, түүнээс доош бол доогуур өсөлтийн түвшинтэй буюу намхан хүүхэд гэж үзнэ. Харин 7 настай дундаж түвшнээс 127.9 см хүртэлх нь дундаас дээгүүр буюу түүнээс дээш үзүүлэлттэй бол дээгүүр үзүүлэлт буюу өндөр хүүхэд гэж үзнэ.

**Танин мэдэхүйн хөгжил:** Юмстай үйлдэл хийх, харах замаар суралцдаг, сонирхолтой, зориудаар анхаарлаа төвлөрүүлэх чадвар илэрхий сайжирна, анхаарал нь хялбар сарнидаг, мэдээллийг цээжлэх замаар тогтооно, бодитоор харж дүрсэлж сэтгэх нь давамгай. Үгийн нөөц нэмэгддэг, бүтэн өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх, ойлгох чадвар сайжирна.

**Нийгэмшлийн онцлог:** Танин мэдэх сонирхол нэмэгдэж, сурах үйл идэвхжинэ. Сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмжээ илэрхийлнэ. Дүрэм, зааврыг ойлгож дагах чадвартай. Хариуцлагатай хандах, бие даах хүсэл эрмэлзлэлтэй болно.

### Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдрын хөгжил (6-10 нас)

#### Бие бялдрын хөгжил

Биеийн жин (кг)										
Биеийн жин хөвгүүдийн хувьд 6-7 насанд 1.77 кг, 7-8 насанд 4.07 кг, 8-9 насанд 1.82 кг, 9-10 насанд 4.84 кг-аар; охид 6-7 насанд 2.14 кг, 7-8 насанд 3.64 кг, 8-9 насанд 2.92 кг, 9-10 насанд 4.62 кг-аар нас тутамд нэмэгдсэн байна.										
Түвшин	Хөвгүүд					Охид				
	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас
Дээд	30.43	32.08	39.49	40.78	52.23	27.15	30.8	37.21	40.63	46.4
Дунджаас дээгүүр	24.3	26.63	30.58	32.86	37.44	23.57	26.02	29.78	32.26	36.95

Дундаж	22.38	24.44	27.81	29.84	33.54	21.71	23.85	26.94	29.16	32.99
Дунджаас доогуур	20.97	22.7	25.39	27.79	30.58	20.12	22.35	24.77	27.29	30.18
Доод	18.75	20.85	22.82	24.83	27.05	18.18	20.13	22.51	23.55	26.36

#### Биеийн өндөр (см)

Биеийн өндрийн үзүүлэлт жилд охидууд 6-7 насанд 4.4см, 7-8 насанд 6.1 см, 8-9 насанд 5.3 см, 9-10 насанд 6.8 см-ээр өссөн, хөвгүүд 6-7 насанд 5.4 см, 7-8 насанд 5.8 см, 8-9 насанд 3.9 см, 9-10 насанд 5.9 см-ээр өссөн байна.

Түвшин	Хөвгүүд					Охид				
	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас
Дээд	124.87	130.11	136.13	141.91	148.52	124.5	128.75	136.5	142.68	148.06
Дунджаас дээгүүр	120.02	125.59	131.6	136.27	142.35	119.07	124.5	130.77	136.52	142.05
Дундаж	117.23	122.79	128.33	133.15	138.52	116.51	121.49	128.16	132.68	137.83
Дунджаас доогуур	114.54	120.03	125.77	130.1	134.75	113.63	118.88	124.9	129.34	134.76
Доод	110.04	115.11	120.91	124.99	128.6	110.01	114.3	120.22	123.18	130.23

#### Цээжний тойрог (см)

Цээжний тойрог хөвгүүдийн хувьд 6-7 насанд 1.24 см, 7-8 насанд 3.51 см, 8-9 насанд 1.15 см, 9-10 насанд 4.07 см-ээр; охид 6-7 насанд 1.19 см, 7-8 насанд 3.13 см, 8-9 насанд 2.18 см, 9-10 насанд 3.56 см-ээр нэмэгдсэн байна.

Түвшин	Хөвгүүд					Охид				
	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас
Дээд	65.76	65.76	73.94	74.94	74.94	64.02	64.02	73.14	74.64	74.64
Дунджаас дээгүүр	60.48	60.48	65.09	67.17	67.16	60	60	64.95	66.7	66.7
Дундаж	59	59	62.47	64.49	64.49	58	58	62.42	63.77	63.77
Дунджаас доогуур	57.59	57.59	60.52	62.42	62.42	56.55	56.55	60.09	61.58	61.58
Доод	54.85	54.85	58.43	59.68	59.68	53.75	53.75	56.62	57.84	57.84

#### Бүсэлхийн тойрог (см)

Бүсэлхийн тойргийн дундаж үзүүлэлт нас нэмэгдэх тусам өссөн үзүүлэлттэй буюу 0.18- 3.49 см-ээр нэмэгдсэн байна.

Түвшин	Хөвгүүд					Охид				
	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас
Дээд	63.88	64.13	69.59	69.49	75.2	60.46	61.75	66.92	69.01	70.78
Дунджаас дээгүүр	56.98	57.68	60.01	61	63.38	55.62	57.06	59.44	59.88	61.31

Дундаж	54.44	55.41	57.14	58.45	60.04	53.58	54.43	56.49	57.48	58.24
Дунджаас доогуур	52.61	53.32	54.65	56.05	57.1	51.5	52.47	54.55	55.12	56.57
Доод	49.48	49.58	52.07	52.32	53.89	48.57	49.27	50.84	51.42	52.98

### Бие бялдрын чадварыг дэмжих үйл

- Биеийн тамирын хичээлд идэвхтэй дур сонирхолтой, жигд оролцоог хангах. Үүний тул биеийн тамирын багш нараас зөвлөгөө авах, сургалтаад дэмжиж буй чадварыг гэрийн нөхцөлд хэрхэн дэмжих талаар эцэг эх, асран хамгаалагчид зохих хэмжээний ойлголттой байх хэрэгтэй.
- Бие бялдрын өсөлт хөгжлийн үзүүлэлтийг жилд 1-2 удаа сургууль тогтоох ёстой бөгөөд хэрэв өөрчлөлт ороогүй бол учир шалтгааныг заавал тодруулах ёстой. Багш эцэг эх асран хамгаалагчдын хамтын ажиллагаа энд нэн чухал.
- Сургуулийн бага нас нь хүүхдийн том булчингийн хөгжлийн үе тул хөдөлгөөний эвсэл, том булчингийн хөгжилд ач холбогдолтой спортын секц дугуйланд явуулах (жишээлбэл, хөлбөмбөг, бассейн, хөнгөн атлетик гэх мэт). Том б
- Жижиг булчингийн хөдөлгөөнийг дэмжихийн тулд леги эвлүүлэх, зураг эвлүүлэх, зураг зурах, будах, хайчлах, наах зэрэг үйлдлийг хийлгэх
- Тогтмол 20-21 цагийн хооронд унтуулдаг байх

### Бие бялдрын бэлтгэлжилт

<b>Хөдөлгөөний эвсэл: 3x10 м (сек) (10 м зурвасын хооронд 3 удаа гүйсэн хугацааг хэмжинэ.)</b>										
Хүүхэд орон зайг баримжаалан өөрийн хөдөлгөөнөө удирдаж, хөдөлгөөний үйлдлийг хурдтай гүйцэтгэх чадвар сургуулийн бага наснаас эрчимтэй хөгжиж эхэлнэ. Ялангуяа нарийн эв дүй хэрэгцээт хөдөлгөөний чадвар хөгжих үндэс суурь сургуулийн бага насанд тавигдана.										
	Хөвгүүд Охид									
	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас
Дээд	8.53	9.36	8.83	8.58	8.29	9.01	9.58	9.32	8.88	8.61
Дунджаас дээгүүр	10.27	10.09	9.61	9.21	9.05	10.83	10.52	10.08	9.68	9.34
Дундаж	11.02	10.53	10.08	9.72	9.42	11.57	11.12	10.51	10.15	9.81
Дунджаас доогуур	11.9	11.24	10.64	10.22	10.07	12.46	11.92	11.13	10.7	10.29
Доод	13.94	13.42	11.58	11.94	11.4	14.69	13.72	12.45	11.88	11.15

### Зүүн гарын атгах хүч (кг)

Бага ангийн 6-10 насны хүүхдийн том булчин нилээд хөгжиж булчингийн чадал нэмэгдэх боловч, гарын сарвууны булчин болон жижиг булчингийн хөгжил хангалтгүй байдаг бөгөөд жилд 1-2 кг аар нэмэгддэг байна. Хөвгүүдийн зүүн гарын атгах хүчний дундаж үзүүлэлт нас нэмэгдэх тусам 1.07- 2.16 кг-аар нэмэгдсэн байна.

Түвшин	Хөвгүүд					Охид				
	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас
Дээд	9.21	10.58	12.77	15.64	18.53	8.55	9.09	11.14	13.5	16.94
Дунджаас дээгүүр	6.52	7.95	10.03	12.11	14.16	5.38	6.44	8.33	10.26	12.25
Дундаж	5.08	6.4	8.33	9.51	11.43	4.12	5.11	6.44	8.53	10.36
Дунджаас доогуур	4.02	5.05	6.47	7.77	9.51	3.05	3.99	5.07	6.59	8.14



Доод	2.27	3.11	4.27	5.2	5.88	0.92	2.31	2.89	3.74	4.69
------	------	------	------	-----	------	------	------	------	------	------

### Баруун гарын атгах хүч (кг)

Бага ангийн 6-10 насны хүүхдийн том булчин нилээд хөгжиж булчингийн чадал нэмэгдэх боловч, гарын сарвууны булчин болон жижиг булчингийн хөгжил хангалтгүй байдаг бөгөөд жилд 1-2 кг аар нэмэгддэг байна Хөвгүүдийн баруун гарын атгах хүчний дундаж үзүүлэлт нас нэмэгдэх тусам 1.07- 2.16 кг-аар нэмэгдсэн байна.

Түвшин	Хөвгүүд Охид									
	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас
Дээд	9.21	10.58	12.77	15.64	18.53	8.55	9.09	11.14	13.5	16.94
Дунджаас дээгүүр	6.52	7.95	10.03	12.11	14.16	5.38	6.44	8.33	10.26	12.25
Дундаж	5.08	6.4	8.33	9.51	11.43	4.12	5.11	6.44	8.53	10.36
Дунджаас доогуур	4.02	5.05	6.47	7.77	9.51	3.05	3.99	5.07	6.59	8.14
Доод	2.27	3.11	4.27	5.2	5.88	0.92	2.31	2.89	3.74	4.69

### Хөлийн хүч: Байрнаас уртад харайлт (см) (Байрнаас хоёр хөлөөр түлхэн уртад харайсан зайг хэмжинэ. 3 удаагийн харайлтын хамгийн холыг тооцно.)

Сургуулийн бага насанд хөлийн хүч нь гарын хүчнээсээ илүү хурдацтай хөгжинө. Хөлийн түлхэлтийн хүч хүүхдийн нас нэмэгдэх тусам сайжирна. Энэ нь тэд өдөр тутам алхах, гүйх, үсрэх харайх хөдөлгөөний үйлдлийг олон хийдэгтэй холбоотой. Хөлийн хүчний үзүүлэлт хөвгүүд, охидын хувьд нас нэмэгдэх тусам 4 см-9 см -ээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Түвшин	Хөвгүүд					Охид				
	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас
Дээд	126.08	143.22	147	161.14	163.71	113.08	125.58	135.37	140.14	151.7
Дунджаас дээгүүр	108.75	123.27	132.66	144.88	146.15	96.78	109.78	118.68	126.31	138.29
Дундаж	98.53	112.63	122.66	133.63	135.96	88.8	100.08	108.08	116.08	128.53
Дунджаас доогуур	88.57	102.41	112.89	123.97	125.85	79.58	91.3	97.93	105.68	118.42
Доод	73.08	85.24	99.13	109.64	106.05	65.34	78.5	86.47	90	101.18

### Гарын хүч: Гар дээр суниалт (удаа) (Тулж хэвтсэн байдлаас 30 сек гар дээрээ суниасан тоог тоолно.)

Сургуулийн бага насанд хүүхдийн гарын том бүлэг булчингийн хүч бага хөгжинө. Бичих, зурах, будах ажлын нөлөөгөөр гарын сарвууны болон хурууны булчигууд бэхжинэ. Гар дээр суниах тоо жилд дунджаар 1-3 удаагаар нэмэгдсэн байна.

Түвшин	Хөвгүүд					Охид				
	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас

Дээд	23.15	25.26	25.23	28.59	29.55	20.25	20.62	23.03	23.44	24.42
Дунджаас дээгүүр	16.32	19.53	20.05	22.3	22.6	13.59	15.62	16.91	18.6	19.68
Дундаж	12.7	15.3	16.41	18.81	17.42	9.8	13.05	12.58	14.5	15.38
Дунджаас доогуур	9	12.2	12.43	14.15	13.39	6.21	9.82	8.86	10.56	11.68
Доод	3.95	6.95	4.67	8.12	6.72	1.2	3.45	3.22	4.63	5.21

**Уян хатан: (см) Хөлөө жийж суусан байдлаас бөхийж, гарын хурууг өлмийнөөс цааш гаргасан зайг хэмжинэ.**

Хөдөлгөөний үйлдлийг хамгийн их далайцаар гүйцэтгэх чадавх буюу уян хатны үзүүлэлт 6-10 насанд ойролцоо буюу 1-2 см хэлбэлзэлтэй байна. Гэхдээ судалгааны үр дүнгээс 10 настай хөвгүүдэд уян хатны үзүүлэлт буурах байдал ажиглагдсан ба суугаа байдлаас бөхийхөд гарын хуруу нь өлмийдөө хүрэхгүй сурагч байсныг онцгой анхаарах шаардлагатай байна.

Түвшин	Хөвгүүд					Охид				
	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас
Дээд	10.95	12.28	10.94	13.83	13.18	13.05	13.88	12.82	13.83	13.9
Дунджаас дээгүүр	7.65	7.85	6.99	8.18	7.87	8.78	9.13	8.43	9.04	9.96
Дундаж	4.97	5.06	4.30	5.61	5.07	6.63	5.79	5.97	5.68	7.1
Дунджаас доогуур	2.5	2.64	2.48	3.40	2.18	3.86	2.97	3.12	3.07	3.5
Доод	-2.22	-1.97	-2.30	-2.22	-3.81	-0.25	-1.33	-1.71	-1.73	0.85

**Бие бялдрын чадварыг дэмжих үйл**

- Гадаа зориулалтын талбайд уралдаж гүйлгэх, хөөцөлдөх, хөл бөмбөг тоглуулах гэх мэт хурд авхаалж самбаа шаардсан үйлдлийг хийлгэхдээ амьсгалын дасгалын дадал суулгах нь чухал.
- Хөлийн булчингийн хүчийг хөгжүүлэхийн тулд түлхэлтэйгээр харайх дасгалыг хийлгэдэг байх. Сууж босох дасгалыг нэг хөл дээрээ суух, завилж суух, сөхөрч суух зэргээр хийлгэж дадах хэрэгтэй.
- Авхаалж самбаа, хөдөлгөөний тэнцвэрийг хөгжүүлэхийн тулд хөдөлгөөнт хөгжөөнт тоглоомоор идэвхтэй тоглуулах. Нэг хөл дээрээ зогссон бол эсрэг хөл дээрээ заавал зогсох ёстой тул ээлжэн зогсоох, бүтэн ул болон өлмийн дээрээ суух дасгалыг өдөр болгон хийхэд нь дэмжих. Мөн мөлхөх авирах, байрандаа гүйх, байрандаа үсрэх дасгалыг тогтмол хийлгэх.

**Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил (6-10 нас)**

Шалгуур	Хүртэхүй		Чадварыг дэмжих үйл
	Үзүүлэлт		
	6-7 нас	8-10 нас	

<b>Ажиглан хүртэх чадвар</b>	Юмсыг бүхэлд/ерөнхийд нь хүртэж ойлгодог. Бүтэц бүрэлдэхүүнийг ажиглан хүртэх нь хүчин чармайлт, хугацаа шаардах нь их. 5-7 хүртэлх тооны танил юмсын ялгаатай болон төстэй шинж, дутуу зүйлийг богино хугацаанд нэрлэх чадвартай;	Юмсын хэлбэр, хэмжээ, тоо, байрлал зэргийг харьцуулан төстэй ба ялгааг хүртэх чадвартай байх; Танил юмсын бүтэц бүрэлдэхүүнийг хурдан хугацаанд таньж хүртэх чадвартай; Нарийн бүтэц бүрэлдэхүүнийг ажиглах нь хүчин чармайлт хугацаа шаардах нь бий. 10 гаруй онцлог ялгаатай зүйлсээс богино хугацаанд харьцуулан 5-7 хүртэлх ялгаатай ба төстэй шинжийг оновчтой хүртэж нэрлэнэ.	Үзэгдэл юмсын ялгаатай ба төсөөтэй шинж байдлыг ажиглах, нэрлэх, юмсын өвөрмөц онцлог, бүтцийг нь хурдан хугацаанд ажиглах ажигч чадварыг дэмжих, ялангуяа 8 наснаас эхлэн юмсын учир шалтгаан, нарийн бүтэц бүрэлдэхүүнийг ажиглах, тайлбарлуулах;
<b>Анхаарал</b>			
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>		<b>Чадварыг дэмжих үйл</b>
	<i>6-7 нас</i>	<i>8-10 нас</i>	
<b>Анхаарлаа төвлөрүүлэх чадвар</b>	Хэлбэр, дүрс, тоо, тэмдэгт бүхий мэдээлэлд анхаарлаа төвлөрүүлэх чадвартай байх; Анхаарлаа төвлөрүүлэн 1 минутын хугацаанд дунджаар 6-8 хүртэлх дүрс тэмдэглэгээ буюу +, - гэх мэт энгийн тэмдэглэгээ хийх чадвартай;	Анхаарлаа зориудаар төвлөрүүлэн ажиллах чадвар нэмэгдэнэ. Хэлбэр, дүрс, энгийн тоо, тэмдэгтээс гадна унших, бичих, бодох оюуны үйлдлийг анхаарлаа төвлөрүүлэн зориудаар гүйцэтгэх чадвартай; Дунджаар 1 минутад 15-20 хүртэлх энгийн дүрс тэмдэглэгээ хийх чадвартай болно.	Анхаарлаа төвлөрүүлэн хурдтай ажиллах чадварыг нь байнга хийх, жишээлбэл, хараад, уншаад тэмдэглэх, ойлгох, ярих, тооны үйлдлийг хугацаатай гүйцэтгэх гэх мэт;
<b>Ой тогтоолт</b>			
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>		<b>Чадварыг дэмжих үйл</b>
	<i>6-7 нас</i>	<i>8-10 нас</i>	
<b>Мэдээллийг тогтоох чадвар</b>	Богино хугацаанд хараад тогтоох: Богино хугацаанд зорилготойгоор 6-7 танил дүрс зургийг хараад тогтоож сэргээн санах чадвартай; цифр/үг гэх мэтийг хараад 3-4 хүртэлхийг тогтоох чадвартай;	Мэдээллийг зориудаар тогтоох чадвар сайжирна. <i>Богино хугацаанд тогтоох:</i> Хоорондоо холбоо багатай тоо, дүрс, бодит утгатай үгийг хараад, 6-7 хүртэлхийг тогтоон сэргээн санана; цифр/үг гэх мэтийг хараад 3-4 хүртэлхийг тогтоох чадвартай;	Хичээл дээр харж тогтоох зүйлс нь 6-7 хүртэлх байх;

	Богино хугацаанд сонсоод тогтоох: Богино хугацаанд зорилготойгоор 4-5 хүртэлх үгийг тогтоож сэргээн санах чадвартай;	Богино хугацаанд сонсоод тогтоох: зорилготойгоор сонсоод 4-5 хүртэлх үгийг тогтоож сэргээн санах чадвартай;	Үг тогтоолгохдоо 4 хүртэлхийг тогтоолгоод аажмаар тоог нэмэгдүүлэх;
	Мэдээллийг утгаар нь тогтоох: энгийн хялбар үйл явдалтай үлгэр өгүүллэгээс утгыг 13-14 хүртэлх тогтоож сэргээн санах чадвартай.	Мэдээллийг утгаар нь тогтоох: Ойролцоогоор 24 утгын нэгжтэй нарийн үйл явдалтай богино хэмжээний өгүүллэг, үлгэрээс 13-14 хүртэлхийг утгаар нь тогтоож сэргээн санах чадвартай;	Эх уншуулж тогтоолгохдоо 15 хүртэлх энгийн үг хэллэг бүхий утгын нэгжээс хэтрэхгүй байх, аажмаар тоог нь нэмэгдүүлэх, тогтоолгосон зүйлээ бичих эсвэл ярих гэх мэт үйлийг тогтмол хийх;
<b>Сэтгэхүй</b>			
<b>Шалгуур</b>	<b>6-7 нас</b>	<b>8-10 нас</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<b>Сэтгэхүйн ангилах, нэгтгэн дүгнэх чадвар</b>	Юмсыг эсрэг шинжээр нь, өнгө хэлбэр, дүрс зэрэг шинжээр нь харьцуулан ялгаатай ба төсөөтэй талыг таних чадвартай;  Бодит юмсыг заан нэрлэсэн танил үгсийн утгыг харьцуулан нийтлэг шинжээр нь ангилах, нэгтгэн дүгнэх чадвартай;	Өмнөх насны онцлог хадгалагдана. Хийсвэр үгийн утгыг харьцуулан нийтлэг шинжээр нь ангилах чадвар хөгжинө.	Үгийг төрөл, зүйл, утгаар нь бүлэглэх үйлдлийг хийх; хичээлийн агуулгыг холбоо хамаарлаар нь ангилах үйлдлийг хийх гэх мэт. Учир шалтгаанд нь хийсвэрээр сэтгэх чадварыг дэмжихдээ бодит үйдэл, дүрслэл дээр тулгуурлах, дэс дараалалтай сэтгэн бодох чадварыг нь дэмжих, харилцан ярилцах;
<b>Бодит сэтгэхүйн чадвар</b>	5-7 хүртэлх энгийн дүрс, шугаман дүрсийг зураас, шугмын дагуу зөв зурах, будах, эвлүүлэх, угсрах чадвартай байна.	Юмсыг бодитоор мэдэрч харсны үндсэн дээр учир шалтгаан, зүй тогтол, холбоо хамаарлыг нь таньж нэгтгэн дүгнэх	Хараад, уншаад учир шалтгааныг нь олох үйлдлүүдийг тогтмол хийх;
<b>Математик сэтгэхүйн чадвар</b>	Энгийн нэмэх, хасах үйлдэлтэй бодлогыг бодох чадвартай; үржүүлэх хуваах үйлдэлтэй, 2 үйлдэлт учир шалтгаанд нь сэтгэх даалгаврыг гүйцэтгэх нь бэрхшээлтэй байх нь бий. сэтгэхүйн тооцоолох чадвар илэрхий сайжирдаг нь 10 нас.		Анхаарлаа төвлөрүүлэн үржүүлэх, хуваах үйлдэлтэй бодлогыг бодох, 1 ээс дээш үйлдэлтэй бодлогыг бодох үйлдлийг гүйцэтгэх;
<b>Хэл яриа</b>			
<b>Шалгуур</b>	<b>6-7нас</b>	<b>8-10 нас</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<b>Үгийн утга тайлбарлах чадвар</b>	Хэл ярианд нь бодит утгатай ахуйн үг давамгайлдаг, хийсвэр утгатай үг, тэмдэг нэр, салаа/ижил утгатай үгийн утгыг тэр бүр ойлгохгүй байж болно. Үгийн утгыг илэрхийлж буй юмсын үзүүлэх нөлөө, гадаад шинж байдлаар нь тайлбарлах чадвартай;		Үгийн утгыг гол утгаар нь тайлбарлах, бүлэглэх үйлдлийг дэмжих; Үгийн хийсвэр утгыг ойлго х тайлбарлах чадварыг нь дэмжих;

<p><b>Ярих чадвар</b></p>	<p>Энгийн богино өгүүлбэрээр ярина. Юмс үйл явдлыг гадна харагдаж байгаа төрх үйл явдлаар нь тоочин ярина; 2 минутад ойролцоогоор 36-37 үгээр ярьдаг байна.</p>	<p>9 наснаас эхлэн нийлмэл өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх чадвар сайжирна; Юмс үйл явдлыг гадна харагдаж байгаа төрх үйл явдлаар нь тоочин ярьдаг өмнөх насны онцлог хадгалагдана; 10 наснаас ерөнхийд нь дүгнэж ярьдаг болно; 2 минутад ойролцоогоор 36-37 үгээр ярьдаг байна.</p>	<p>Санаа бодлоо бүтэн өгүүлбэрээр илэрхийлэх чадварыг дэмжих; 8-9 наснаас эхлэн нийлмэл өгүүлбэрээр илэрхийлэх чадварыг дэмжих; Эх уншаад утгыг нь ярих, бичих үйлийг хийх; Зураг хараад сэтгэгдлээ уяир шалгаанд нь ярих үйлийг хийх;</p>
---------------------------	---	--	--

### Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (6-10 нас)

<b>Өөртөө хандах хандлага</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- <b>Өөртөө итгэлтэй байх чадвар;</b></li> <li>- <b>Өөрийгөө хүлээн зөвшөөрөх чадвар;</b></li> <li>- <b>Өөрийн үнэлэмж эерэг байх чадвар;</b></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Баяр баясгалантай. Найз нөхөд, багштайгаа харилцахдаа бэрхшээдэггүй, нийтэч. Өөрийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлнэ.</li> <li>- Өөрийгөө буруутгадаггүй. Өөрийн гадаад байдал, зан чанартаа эерэг хандана .</li> <li>- Өөрийгөө бусадтай харьцуулдаггүй.</li> <li>- Охидын өөртөө итгэх итгэл хөвгүүдтэй харьцуулахад илүү байж болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бодитоор урамшуулах, өөрийн талаарх эерэг төсөөллийг нь бэхжүүлэх, хөвгүүдийн өөртөө итгэх итгэлийг нь бодитоор дэмжих;</li> <li>- Хүн бүр алдаа гаргах, сул талтай байж болох талаар ойлгуулах, хүүхдийн сонирхлыг хөгжүүлэх, сонирхдог зүйлийнх нь тухай ярилцах;</li> </ul>
<b>Зан төлөв</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- <b>Идэвхтэй байх чадвар;</b></li> <li>- <b>Зан төлөвөө удирдах чадвар;</b></li> <li>- <b>Сэтгэл санаа тогтвортой байх чадвар</b></li> <li>- <b>Сэтгэл гутрал, айдас бага байх чадвар;</b></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хичээлийн үеэр идэвх, оролдлоготой байна. Сурах урам зоригтой.</li> <li>- Багшийн зааврыг дагаж биелүүлнэ. Гэрийн даалгавраа санаачилгаараа хийнэ.</li> <li>- Уурлаж бухимдах нь бага байна.</li> <li>- Уйтгартай байдлаас баяр баясгалантай байдалд амархан шилжинэ. Заримдаа баяр баясгалантай байдал нь</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Шшүүмжлэхгүй байх, байгаагаар нь хүлээн зөвшөөрөх, ойр дотно харилцан ярилцах;</li> <li>- Бусад хүмүүс, ялангуяа үеийн хүүхдэдээ анхаарал халамж тавих чадварыг нь дэмжих,</li> <li>- Үе тэнгийнхэндээ хүндэтгэлтэй хандах чадварыг дэмжих;</li> <li>- Хүүхэд уйтгар гунигтай байгаа тохиолдолд асууж ярилцах, хүүхдийг</li> </ul>

	<p>уйтгар гунигаар солигдох нь хурдан. Нөхцөл байдалд зохицуулан зан төлөвөө удирдах чадвартай.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 7 наснаас эхлэн хүүхэд өөрийн зан төлөвтөө шүүмжлэлтэй хандах нь ажиглагдана.</li> </ul>	анхааралтай хүндэтгэлтэй сонсох;
<b>Сэтгэлийн хөдөлгөөн</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- <b>Өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг таних чадвар;</b></li> <li>- <b>Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар;</b></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн болон эцэг эх, найз нөхдийнхөө баяр хөөр, уйтгар гуниг, уур бухимдал түүний учир шалтгааныг мэддэг байна.</li> <li>- Өөрийг нь баярлуулж, гомдоох зүйлсийн талаарх ойлголттой байна.</li> <li>- Сэтгэл хөдлөлөө үгэн болон үгэн бус хэлбэрээр илэрхийлнэ.</li> <li>- Бусдын сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг хараад таних чадвартай, нөхцөл байдалд тохируулан сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах чадвартай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх чадварыг дэмжих;</li> <li>- Хүүхэд юунд баярладаг, гомддог талаар ярилцах, сэтгэлийн хөдөлгөөний илрэлийнх нь учир шалтгааны талаар ярилцах,</li> <li>- Бусдын сэтгэл санааг ойлгох, дэмжих чадварыг нь дэмжих, хүүхдийг буруутгахаас зайлсхийх;</li> </ul>
<b>Харилцаа</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- <b>Идэвхтэй харилцах чадвар;</b></li> <li>- <b>Бусадтай хамтрах чадвар;</b></li> <li>- <b>Гэр бүл, найз нөхөд болон үе тэнгийнхнийхээ үзэл бодлыг хүндэтгэх чадвар;</b></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг, эх багшийн зааврыг дагаж, бусадтай мэдлэг туршлага солилцож, дэмжлэг авдаг байна.</li> <li>- Найз нөхөд үе тэнгийхэндээ хандах эерэг хандлагатай, хамтран ажиллах чадвартай, сургууль дээр зохиогдсон ажилд идэвхтэй оролцоно.</li> <li>- 9, 10 насанд тухайн хүүхдийн бусадтай хамтрах, харилцах сонирхол буурах нь ажиглагдаж болно.</li> <li>- Бусдын сэтгэл санааг ойлгож хандах чадвартай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэдтэй илэн далангүй нээлттэй нөхөрсөг харилцах;</li> <li>- Үе тэнгийнхэнтэйгээ харилцах чадварыг дэмжих;</li> <li>- Олон нийтийн үйл ажиллагааны оролцоог дэмжих;</li> <li>- Хүүхдэд дотно, хүндэтгэлтэй хандах;</li> </ul>
<b>Энэгшилт</b>		

Шалгуур	Үзүүлэлт	Чадварыг дэмжих үйл
- <b>Эцэг эх, асран хамгаалагчдадаа итгэх, ойр дотно харилцах чадвар;</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг эх, асран хамгаалагч, ойр дотны хүмүүсийнхээ дэмжлэг, хайр халамжид (итгэдэг, найддаг) байна.</li> <li>- Эцэг эх, ойр дотны хүмүүстэйгээ дотно, эерэг, нээлттэй харилцаатай байна.</li> <li>- Ээж аав эсвэл ойр дотны асран хамгаалагчтайгаа байх нь таатай, зарим тохиолдолд эцэг, эхийнхээ дэмжлэг туслалцаагүйгээр бие дааж асуудал шийдвэрлэж чадахгүй байх нь бий. Тэднээс тусдаа байх нь түгшүүр үүсгэх нь элбэг.</li> </ul>	Ээж аав нь хүүхдэдээ илүү анхаарал халамж тавих, илэн далангүй харилцах харилцах;
<b>Дасан зохицолт</b>		
Шалгуур	Үзүүлэлт	Чадварыг дэмжих үйл
- <b>Бусдад хүндэтгэлтэй хандах чадвар;</b> - <b>Зан төлөвөө удирдах чадвар;</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Бусдын зан төлөв ба ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрнө, Бие даан сурах, зан төлөвөө зохицуулах чадвартай, жишээлбэл, хүнээр хэлүүлэхгүйгээр бие даан гэрийн даалгавраа хийх, шүдээ угаах, гараа угаах гэх мэт.</li> <li>- Насанд хүрэгчдийн заавар зөвлөгөөг дагана. Нас нэмэгдэхэд хүүхдүүд алив зүйлд өөрийн хүсэл сонирхлоор хандах нь ажиглагдана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бусад хүмүүс ялгаатай байж болох, түүнд хүндэтгэлтэй, тэгш хандах талаар ойлголт өгөх;</li> <li>- Дүрэм журмыг баримтлах, бие даан зан төлөвөө зохицуулах чадварыг нь хөхүүлэн дэмжих;</li> </ul>
<b>Үнэт зүйл</b>		
Шалгуур	Үзүүлэлт	Хөгжлийг дэмжих үйл
- <b>Аюулгүй тайван байх, бусдад хүндэтгэлтэй хандах, бусдыг гадуурхахгүй байх тухай ойлголт;</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Юу чухал, юу чухал биш талаар ойлголттой болсон байна.</li> <li>- Аюулгүй байх нь хамгийн чухал гэж үздэг. Бусдыг хүндлэх, ах, эгчээ хүндлэх нь маш чухал гэсэн ойлголттой.</li> </ul>	Бусад хүмүүс ялгаатай байж болох, түүнд хүндэтгэлтэй, тэгш хандах талаарх ойлголтыг дэмжих;
<b>Нийгмийн хэм хэмжээ</b>		
Шалгуур	Үзүүлэлт	Чадварыг дэмжих үйл

<ul style="list-style-type: none"> <li>- Дүрэм журмыг дагах чадвар;</li> <li>- Ёс зүйг баримтлах чадвар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сургуулийн орчинд дотоод дүрэм журмыг ойлгож даган биелүүлэх нь зөв гэсэн итгэл үнэмшилтэй</li> <li>- Багшийн заавар, анги, сургууль доторх дүрэм журамд захирагдана.</li> <li>- Олон нийтийн газар биеэ хэрхэн зөв авч явах талаар ойлголттой, шүлсээ хаях, хог хаях, улаан гэрлээр гарах, бусдад хүндэтгэлгүй хандах, хүнийг шоолох нь буруу гэх итгэл үнэмшилтэй, үүнийг дагахыг эрмэлзэнэ.</li> </ul>	<p>Олон нийтийн газар дүрэм журмыг баримтлах, сургууль, гэр бүлийн хүрээнд баримтлах дүрэм, түүнийг дагах талаарх ойлголт, чадварыг дэмжих;</p>
--	--	---



### III. СУУРЬ БОЛОВСРОЛЫН 11-14 НАСТАЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ШАЛГУУР

#### Хөгжлийн ерөнхий онцлог

**Бие бялдрын хөгжил:** Биеийн өндөр, жин нэмэгдэнэ. Шилжилтийн настай холбоотой бие махбод физиологийн хөгжлийн эрчимтэй үе.

**Танин мэдэхүйн хөгжил:** Хийсвэр сэтгэхүйн хөгжлийн эрчимтэй үе. Үзэгдэл юмсыг учир шалтгаан холбоо хамааралд нь хийсвэрлэн сэтгэх чадвар нэмэгдэнэ. Шинжлэх ухааны мэдлэг эзэмшсэнээр өргөн хүрээнд танин мэдэх чадвартай болно. Танин мэдэхүйн сонирхол хөгждөг.

**Нийгэмшлийн онцлог:** Сонирхол нь гүнзгийрэн хөгжинө. Ирээдүйн мэргэжил сонголтын талаар бодож төлөвлөнө. Мөрөөдөмтгий болно. Үе тэнгийнхэнтэйгээ харилцах хүсэл эрмэлзэлтэй болж цагийг хамтдаа өнгөрөөх сонирхолтой болно. Түгшүүрт амархан автагдаж, сэтгэл санааны байдал өөрчлөгдөх нь хялбар. Өөрийн тухай ойлголт хандлага өөрчлөгдөж бие даасан байдлаа мэдрэхийг хүсдэг, насанд хүрсэн хүн мэтээр ойлгож төсөөлөх нь түгээмэл.

#### Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдрын хөгжил (11-14 нас)

##### Бие бялдрын хөгжил

Биеийн жин (кг)								
11-14 нас эрчимтэй хөгжлийн гурав дахь үе учир хөвгүүдийн биеийн жин нилээд өндөр хэмжээгээр нэмэгддэг байна. Охидын биеийн жин жилд 11-12 насанд 3.48 кг, 12-13 насанд 4.36 кг, 13-14 насанд 2.82 кг- аар нас тутамд нэмэгдсэн. Хөвгүүд 11-12 насанд 3.5 кг, 12-13 насанд 4кг, 13-14 насанд 6 кг аар нэмэгдсэн байна. Энэ насанд хөвгүүдийн биеийн жин эрчимтэй нэмэгдсэн байна.								
Түвшин	11 нас	12 нас	13 нас	14 нас	11 нас	12нас	13 нас	14 нас
	Хөвгүүд				Охид			
Дээд	51.49	56.26	61.41	67	52.89	57.65	63.36	60.7
Дунджаас дээгүүр	40.71	44.58	50.69	54.89	43.11	48.05	52.13	54.64
Дундаж	36.29	40.1	44.77	50.06	39.15	43.63	48.13	50.73
Дунджаас доогуур	33.18	35.66	40.4	45.25	35.02	39.34	43.93	46.62
Доод	29.64	31.47	34.99	39.93	29.81	33.48	38.29	40.83

Биеийн өндөр (см)								
11-12 насанд охидын өндрийн үзүүлэлт хөвгүүдийнхээс түрүүлж 13-14 хөвгүүдийн биеийн өсөлт эрчимжиж охидыг гүйцэж түрүүлнэ. Энэ нь бие бялдрын эрчимтэй өсөлтийн гурав дахь үетэй холбоотой байна. Биеийн өндрийн үзүүлэлт 11-12 насанд охид 4,74 см-ээр, 12-13 насанд 3.81 см, 13-14 насанд 2.41 см -ээр тус бүр нэмэгдсэн байна.								
Түвшин	11 нас	12 нас	13 нас	14 нас	11 нас	12 нас	13 нас	14 нас
	Хөвгүүд				Охид			
Дээд	152.88	160.91	168.18	173.11	156.12	160.67	164.33	164.78
Дунджаас дээгүүр	146.41	152.88	160.95	166.07	149.94	155.32	158.7	160.41
Дундаж	142.63	147.68	156.68	161.64	146.55	151.53	155.14	157.37
Дунджаас доогуур	139.21	143.23	150.79	158.11	142.49	147.63	152.19	154.28

Доод	134.24	137.84	143.48	150.3	134.61	140.96	146.45	150.24
------	--------	--------	--------	-------	--------	--------	--------	--------

#### Цээжний тойрог (см)

Дунд ангийн 11 -14 насны хүүхдүүдийн бие махбодын өсөлт хөгжил болон бэлгийн бойжилт хурдасна. Охидын цээжний тойрог жилд 2.4 – 5.3 см-р нэмэгддэг, бол хөвгүүдийн цээжний тойрог 2.6 – 3.7 см нэмэгддэг байна.

Түвшин	11 нас	12 нас	13 нас	14 нас	11 нас	12 нас	13 нас	14 нас
	Хөвгүүд				Охид			
Дээд	79.71	82.81	86.32	88.76	81.8	84.38	88.15	86.81
Дунджаас дээгүүр	72.49	74.04	78.27	81.32	74.69	77.48	80.52	82.37
Дундаж	68.81	71.64	75.41	78.07	70.50	74.26	74.72	79.53
Дунджаас доогуур	66.17	68.78	71.46	74.76	67.28	71.31	74.56	76.77
Доод	62.05	63.46	65.86	69.05	62.61	65.97	69.49	69.92

#### Бүсэлхийн тойрог (см)

11– 14 насанд 3.84 см–1.62 см-ээр нэмэгдсэн байна. Энэ нь биеийн жин нэмэгдсэнтэй холбоотой байна. Охидын бүсэлхийн тойргийн хэмжээ 11 насанд 3.84 см, 14 насанд 1.62 см -ээр нэмэгдсэн байгаа нь биеийн жин ба өндрийн үзүүлэлт нэмэгдсэн холбоотой байж болно.

Түвшин	11 нас	12 нас	13 нас	14 нас	11 нас	12 нас	13 нас	14 нас
	Хөвгүүд				Охид			
Дээд	74.69	75.7	76.17	77.47	74.91	74.29	76.03	75.09
Дунджаас дээгүүр	64.98	66.28	68.07	69.04	65.3	66.23	68.27	69.62
Дундаж	60.68	62.76	64.33	66.06	61.71	62.91	65.34	66.33
Дунджаас доогуур	58.89	60.06	61.36	63.53	58.1	60.18	62.94	63.08
Доод	54.93	56.88	57.72	59.86	54.49	56.12	57.92	59.14

#### Бие бялдрын чадварыг дэмжих үйл

- Өглөөний цайг тогтмол ууж хэвшүүлэх. Өглөө бүр тоот дасгалыг өдөр бүр тогтмол хийх дадалд сурах
- Жилд багадаа 2 удаа жингээ хэмжиж, дундаж хэмжээнээс ямар хэмжилтээрээ өөр байгааг тогтоож, хэвийн жинтэй байхад юуг анхаарах талаар эцэг эхчүүд биеийн тамирын багш болон сургуулийн эмчтэй зөвлөж, зөвлөсний дагуу ажиллах
- Өмнөх насанд гэрийн нөхцөлд хийх дасгалуудыг тогтмол хийж сурах
- Агаарт тогтмол гарч цана чарга, усанд сэлэлт, гимнастик, дугуй унах, багийн спортоор тогтмол хичээллэх, сонирхлын дагуу спортын секц дугуйланд хамруулах
- Биеийн тамирын хичээлд тогтмол оролцох
- 21-22 цагийн хооронд тогтмол унтах дадалд сурах

#### Бие бялдрын бэлтгэлжилт

**Хөдөлгөөний эвсэл: 3x10 м гүйлт (сек) (10 м зурвасын хооронд 3 удаа гүйсэн хугацааг хэмжинэ.)**

Суурь боловсролын түвшинд охидын хувьд 10-12 насанд хөдөлгөөний эвслийн хөгжилд мэдэгдэм ялгаа ажиглагдаагүй бөгөөд 13 насанд ялимгүй буурч, 14 насанд бага зэрэг (0.3 сек) ахисан. Хөвгүүдийн хувьд хөдөлгөөний эвслийн хөгжил 11-13 насанд жигд явагдаж, 14 насанд дундаж үзүүлэлтэд нэлээд ахиц (0.7 сек) ажиглагдсан.

	11 нас	12 нас	13 нас	14 нас	11 нас	12 нас	13 нас	14 нас
Түвшин	Хөвгүүд				Охид			
Дээд	8.13	7.86	7.7	7.35	8.55	8.44	8.53	8.33
Дунджаас дээгүүр	8.7	8.59	8.28	7.94	9.21	9.03	8.99	8.87
Дундаж	9.14	8.99	8.72	8.37	9.65	9.49	9.45	9.28
Дунджаас доогуур	9.78	9.45	9.24	8.79	10.21	10.02	9.95	9.82
Доод	11.49	10.41	10.59	9.87	10.98	11.14	11.16	11.44

### Зүүн гарын атгах хүч (кг)

Суурь боловсролын түвшинд хөвгүүдийн зүүн гарын атгах хүч нас нэмэгдэх тусам 11-12 насанд 2.75 кг, 12-13 насанд 4.99 кг, 13-14 насанд 3.69 кг-аар нэмэгддэг байна.

	11 нас	12 нас	13 нас	14 нас	11 нас	12 нас	13 нас	14 нас
Түвшин	Хөвгүүд				Охид			
Дээд	20.63	23.81	30.93	36.49	20.47	23.73	27.09	27.03
Дунджаас дээгүүр	17.67	19.66	24.72	29	15.68	19.56	21.87	22.82
Дундаж	15.21	17.01	20.36	24.64	12.88	16.15	19.5	20.25
Дунджаас доогуур	12.25	14.53	18.21	21.04	10.39	12.97	15.51	17.48
Доод	8.6	9.58	13.29	15.16	7.21	8.66	10.2	11.53

### Баруун гарын атгах хүч (кг)

Хөвгүүдийн баруун гарын атгах хүч нас нэмэгдэх тусам 11-12 насанд 2.49 кг, 12-13 насанд 2.1 кг, 13-14 насанд 2.94 кг-аар нэмэгдсэн байна.

	11 нас	12 нас	13 нас	14 нас	11 нас	12 нас	13 нас	14 нас
Түвшин	Хөвгүүд				Охид			
Дээд	22.58	25.41	33.35	39.57	21.18	25.64	28.7	29.69
Дунджаас дээгүүр	19.14	20.23	25.78	30.63	17.11	20.43	22.86	24.53
Дундаж	15.6	18.23	21.8	26.16	14.33	17.49	19.68	21.6
Дунджаас доогуур	12.97	15.17	19.46	21.85	11.3	14.33	16.11	19.51
Доод	9.24	11.33	14.14	18.45	8.26	9.42	10.53	12.76

### Хөлийн хүч: БАЙРНААС УРТАД ХАРАЙЛТ (см) (Байрнаас хоёр хөлөөр түлхэн уртад харайсан зайг хэмжинэ. 3 удаагийн харайлтын хамгийн холыг тооцно.)

Хөлийн хүч буюу байрнаас уртад харайх охидын дундаж үзүүлэлт 11-12 насанд 7.32 см, 12-13 насанд 5.28 см-ээр ахисан бол 14 насанд маш бага (0.72 см) ажиглагдсан. Харин хөвгүүдийн хувьд энэ үзүүлэлт 11-12 насанд 7.58 см, 13 насанд 14.05 см-ээр нэмэгдсэн ба 14 насанд хамгийн их буюу 16.57 см-ээр хол харайсан байна.

	11 нас	12 нас	13 нас	14 нас	11 нас	12 нас	13 нас	14 нас
Түвшин	Хөвгүүд				Охид			
Дээд	176.46	183.24	202.24	217.25	159.19	170.73	176.47	169.76
Дунджаас дээгүүр	157.24	167.4	181.03	198.32	142.14	151.06	158.64	157.50
Дундаж	147.88	155.46	169.51	186.08	133.21	140.53	145.81	146.53
Дунджаас доогуур	136.48	146.15	158.57	172.43	121.48	128.5	133.97	136.28
Доод	117.21	125.44	134.32	146.04	106.06	107.09	113.97	116.09

**Гарын Хүч: ГАР ДЭЭР СУНИАЛТ (удаа) (Тулж хэвтсэн байдлаас 30 сек гар дээрээ сунгалтын тоог тоолно.)**

Суурь боловсролын түвшинд хүүхдийн гарын хүч сургуулийн бага насны үеийнхээс сайжрах боловч 11-14 насанд хүч нь огцом нэмэгдэхгүй байна. Гарын хүч маш сайн хүүхдүүд дундаж үзүүлэлтээс 10-аас дээш байгаа нь ижил насны хүүхдүүдээс ялгаа ихтэй байгааг харуулж байна.

Түвшин	11 нас	12 нас	13 нас	14 нас	11 нас	12 нас	13 нас	14 нас
	Хөвгүүд				Охид			
Дээд	29.74	31.15	33.53	34.57	22.29	23.97	22.56	21.57
Дунджаас дээгүүр	22.31	24.94	25.92	26.71	16.28	18.44	18.18	16.53
Дундаж	18.41	20.66	20.76	21.82	13.35	13.57	14.18	12.41
Дунджаас доогуур	13.57	15.62	15.61	17	9.01	9.45	10.53	8.77
Доод	6.32	6.32	7.18	8.54	3.56	3.50	4.12	3.38

**Уян хатан: бөхийлт (см) (Хөлөө жийж суусан байдлаас бөхийж, гарын хурууг өлмийнөөс цааш гаргасан зайг хэмжинэ)**

Суурь боловсролын түвшинд хүүхдийн уян хатны хөгжлийн үзүүлэлт тогтвортой хэмжээнд байсан. Хүүхдийн нас бага байх тусам булчингийн уян налархай байдал илүү байх зүй тогтолтой боловч 11-14 насанд уян хатны үзүүлэлт жилд 1-2 см-ээр ахиж байна. Дунд ангийн охид уян хатны чадвар хөгжлөөр бүх насанд хөвгүүдээс илүү үзүүлэлттэй байна.

Түвшин	11 нас	12 нас	13 нас	14 нас	11 нас	12 нас	13 нас	14 нас
	Хөвгүүд				Охид			
Дээд	13.18	13.54	12.28	15.59	13.9	16.81	17.58	18.78
Дунджаас дээгүүр	7.87	8.35	7.87	9.63	9.96	10.42	11.33	12.59
Дундаж	5.07	4.82	4.77	6.07	7.12	6.96	7.79	8.94
Дунджаас доогуур	2.18	1.93	1.93	2.56	3.53	3.98	3.95	5.92
Доод	-3.81	-3.87	-3.93	-5.75	-0.85	-4.07	-1.92	-2.09

**Бие бялдрын чадварыг дэмжих үйл**

- Хөгжмийн хэмжнэлд дасгал хөдөлгөөн хийх, бүжгийн хөдөлгөөний чадвартай болгох
- Хөдөлгөөнт тоглоом, буухиаг тэмцээнд жигд оролцдог байх
- Сагсан бөмбөг, хөл бөмбөг, гар бөмбөг, усанд сэлэх, цана, тэшүүрээр гулгах гэх мэт спортын тодорхой төрлөөр хичээллүүлэх
- Тохирсон сунгалтын дасгал хийлгэхдээ техникийн дагуу зөв хийж байгааг багш, эцэг эх асран хамгаалагчид хяналт тавих хэрэгтэй.
- Гар дээр суниах чадвартай болгох. Гар дээр суниах дасгалыг техникийн дагуу зөв гүйцэтгэх, суниах тоог аль болох нэмэгдүүлэх, өөрийн насны дундаж тооноос цөөнгүй суниах сурахад нь урамшуулан дэмжих
- Байрнаас уртад харайх чадвартай болгохдоо хүүхдийн гутал хальтирхааргүй нөхцөлд ямар техникээр харайхыг багш нар хичээлүүдээрээ тогтмол сануулж байх хэрэгтэй. Уртад харайх нь хүүхдийн хөгжилд ямар ач холбогдолтойг тайлбарлах шаардлагатай.
- Холын зайд зайд гүйх чадвартай болгохдоо хичээлээс бусад цагуудад хүүхдүүд уг чадвараа хөгжүүлэх ямар боломж байгааг тодруулан багш нар эцэг эх асран хамгаалагчдад чиглэл өгч тэдэнтэй хамтран ажиллах, холын зайд гүйхдээ өөрийн аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар хүүхдүүдийн ойголтыг байнга дэмжих

## Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил (11-14 нас)

<b>Хүртэхүй</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<b>Ажиглан хүртэх чадвар</b>	10 гаруй салангид зүйлсээс богино хугацаанд харьцуулан 7-10 хүртэлх ялгаатай ба төстэй шинжийг оновчтой хүртэж нэрлэнэ. Юмсын бүтэц бүрэлдэхүүнийг хүртэх нь хүчин чармайлт шаардах нь бий.	Юмсын ялгаатай ба өвөрмөц зүйлийг ажиглах, таних чадварыг нь дэмжих;
<b>Анхаарал</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<b>Анхаарлаа төвлөрүүлэх чадвар</b>	Үсэг, тоо, тусгай тэмдэгт бүхий мэдээлэлд зориудаар анхаарлаа төвлөрүүлэх чадвартай байх. 1 минутад ойролцоогоор 25-27 хүртэлх энгийн дүрс тэмдэгт тэмдэглэх чадвартай. Хүчин чармайлт шаардсан үйлдэлд хялбар ядарч анхаарал нь суларч бүтээмж буурах хандлага ажиглагдана.	Үйлдлийг дунджаар 5-10 минут анхаарлаа төвлөрүүлэн алдаагүй хурдтай гүйцэтгэх, оюуны үйлдэлд хүчин чармайлттайгаар анхаарал төвлөрүүлэн ажиллах чадварыг дэмжих;
<b>Ой тогтоолт</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<b>Мэдээллийг тогтоох чадвар</b>	<i>Богино хугацаанд хараад тогтоох:</i> Энгийн дүрс, тэмдэгт зургуудыг хараад 9-10-ыг тогтоож сэргээн санана; цифр/үг зэргийг хараад 5-6 хүртэлхийг тогтоож сэргээн санана.	- Хичээл дээр богино хугацаанд харж тогтоох дүрс тэмдэгтүүд нь 10-11 хүртэлх байх; - Тогтоох үг/цифр зэрэг нь 7 хүртэлх байх;
	<i>Богино хугацаанд сонсоод тогтоох:</i> Богино хугацаанд зорилготойгоор 5-6 хүртэлх үгийг тогтоож сэргээн санах чадвартай.	Хичээл дээр сонсоод тогтоох үгийн тоо нь 7 хүртэлх байх ба аажмаар тоог нь нэмэгдүүлэх;
	<i>Мэдээллийг утгаар нь тогтоох:</i> Байнга хэрэглэгддэггүй үг хэллэгтэй нарийн үйл явдлыг агуулсан өгүүлэг зэргийг тогтоон сэргээн санах чадвартай байх. Мэдээллийг утгаар нь тогтоохдоо нарийн үйл явдал бүхий эхээс 15-16 хүртэлх утгыг тогтоож сэргээн санах чадвартай.	Эхийг уншуулж тогтоолгохдоо 17 хэллэг бүхий утгын нэгжээс хэтрэхгүй байх, аажмаар тоог нь нэмэгдүүлэх, тогтоолгосон зүйлээ бичих эсвэл ярих гэх мэт үйлийг тогтмол хийх;
<b>Сэтгэхүй</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>

<b>Сэтгэхүйн ангилах, нэгтгэн дүгнэх чадвар</b>	<i>Сэтгэхүйн ангилах чадвар:</i> Юмсыг хэлбэр, дүрс, хэмжээ, эсвэл төрөл зүйл, дотоод мөн чанараар нь бүлэглэх чадвартай. <i>Сэтгэхүйн харьцуулах чадвар:</i> Юмсыг эсрэг шинж, өнгө хэлбэр, дүрс, учир шалтгаан холбоо хамаарлаар нь харьцуулан ялгаатай ба төстэй талыг таних чадвартай. <i>Сэтгэхүйн нэгтгэх чадвар:</i> Үзэгдэл юмсыг гадаад шинж, хэрэглээ зориулалтаар нэгтгэх чадвартай, харин мөн чанар, зүй тогтлоор нь нэгтгэн илэрхийлэх нь бэрхшээлтэй байх нь бий.	<ul style="list-style-type: none"> <li>- Үгийг төрөл, зүйл, утгаар нь бүлэглэх үйлдлийг хийх; Хичээлийн агуулгыг холбоо хамаарлаар нь ангилах үйлдлийг хийх;</li> <li>- Үзэгдэл юмсыг ижил төстэй нийтлэг шинжээр нь нэгтгэн нэрлэх гэх мэт үйлдлийг хийх боломжтой;</li> </ul>
<b>Математик сэтгэхүйн чадвар</b>	2 үйлдэл бүхий энгийн бодлогыг бодох чадвартай ба учир шалтгаанд нь сэтгэх 2 ба түүнээс дээш үйлдлийг гүйцэтгэх нь хангалтгүй байх нь бий.	Учир шалтгаанд нь сэтгэх хийсвэр үйлдлийг бодит үйлдэл, дүрслэл дээр тулгуурлан хөгжүүлэх;
<b>Хэл яриа</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<b>Үгийн утга тайлбарлах чадвар</b>	Бодит ахуйн үг, хийсвэр үгийн утгыг түүний үзүүлж буй нөлөө, гадаад шинж төрх байдлаар нь тайлбарлана. Салаа/ижил утгатай үгийн утгыг тэр бүр оновчтой тайлбарлахгүй байх нь ажиглагдана;	Үг/нэр томьёо зэргийг утга мөн чанараар тайлбарлах логик чадварыг дэмжих;
<b>Ярих чадвар</b>	Энгийн богино өгүүлбэрээр ерөнхийлөн дүгнэж ярих хандлагатай. 2 минутад ойролцоогоор 31-32 үгээр ярих	<ul style="list-style-type: none"> <li>- Салаа/ижил утгатай үг, тэмдэг нэрийн үгийн нөөцийн нэмэгдүүлэх;</li> <li>- Нийлмэл өгүүлбэрээр оновчтой бодол санаагаа илэрхийлэх чадварыг дэмжих;</li> </ul>

### Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (11-14 нас)

<b>Өөртөө хандах хандлага</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Өөртөө итгэлтэй байх чадвар;</li> <li>- Өөрийгөө хүлээн зөвшөөрөх чадвар;</li> <li>- Өөрийн үнэлэмж эерэг байх чадвар;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Өөртөө итгэлтэй, давуу ба сул талаа хүлээн зөвшөөрдөг, өөрийгөө бодитоор үнэлдэг.</li> <li>- Өөрийгөө бусадтай харьцуулна. Өөрийн бусдаас ялгаатай гэдгээ хүлээн зөвшөөрнө.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн тухай ойлголтыг нь үйл ажиллагааны чадвартай нь холбож өөрийн тухай бодит ойлголт, үнэлэмжийг бий болгох;</li> <li>- Бусадтай харьцуулахгүй байх, өөрийгөө сайн ба сул талаа хүлээн зөвшөөрч, сул талаа сайжруулах талаар зөвлөн дэмжих;</li> </ul>
<b>Зан төлөв</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>

<ul style="list-style-type: none"> <li>- Нөхөрсөг, нээлттэй харилцах чадвар;</li> <li>- Зан төлөвөө удирдах чадвартай ;</li> <li>- Сэтгэл санаагаа удирдах чадвар;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бусадтай нөхөрсөг, нийтэч харилцдаг, нээлттэй, идэвхтэй харилцаатай, бие даан зан төлөвөө зохицуулах, хариуцлагатай хандах чадвартай.</li> <li>- Сэтгэлийн түгшүүрт автагдах нь хялбар байж болно.</li> <li>- Заримдаа сэтгэл санааны баяр баясгалантайгаас уйтгар гунигт автагдах бий.</li> </ul>	<p>Харилцааны нөхөрсөг, хүндэтгэлтэй, хариуцлагатай, нийтэч зан төлөвийг нь сургууль гэр бүлийн орчинд дэмжих;</p>
<b>Сэтгэлийн хөдөлгөөн</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<p><b>Сэтгэлийн хөдөлгөөнөө таних, удирдах чадвар;</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн болон эцэг эх, найз нөхдийнхөө баяр хөөр, уйтгар гуниг, уур бухимдал түүний учир шалтгааныг мэддэг байна.</li> <li>- Өөрийг нь баярлуулж, гомдоох зүйлсийн талаарх ойлголттой байна.</li> <li>- Сэтгэл хөдлөлөө үгэн болон үгэн бус хэлбэрээр илэрхийлнэ.</li> <li>- Бусдын сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг хараад таних чадвартай, нөхцөл байдалд тохируулан сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах чадвартай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Орчин нөхцөлдөө зохицон сэтгэл хөдлөлөө бие даан зохицуулах чадварыг нь дэмжих,</li> <li>- Бусдын сэтгэл хөдлөлийг таньж ойлгох чадварыг нь дэмжих;</li> </ul>
<b>Харилцаа</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Нээлттэй идэвхтэй харилцах чадвар;</li> <li>- Баг, бүлгээр ажиллах чадвар;</li> <li>- Хүмүүстэй ойр дотно харилцах чадвар;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бусадтай хамтрах, харилцах чадвартай;</li> <li>- Харилцааны үед бусдын сэтгэл санааг ойлгож харилцах чадвартай;</li> <li>- Нээлттэй нөхөрсөг харилцаатай ч зарим тохиолдолд ганцаардмал байдал ажиглагдаж болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бусадтай хамтран ажиллах, баг бүлгийн үйл ажиллагаанд хувь нэмэр үзүүлэх мэдрэмжийг хөгжүүлэх</li> <li>- Бусдын сэтгэл санааг ойлгож харилцах чадварыг дэмжих;</li> </ul>
<b>Энэгшилт</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг эх, асран хамгаалагчдадаа ойр дотно харилцах чадвар;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг эхдээ итгэдэг, тэдэнд дотно хандаж харилцдаг.</li> <li>- Зарим тохиолдолд эцэг эхтэй харилцах нь сул байж болно.</li> </ul>	<p>Ээж аавтайгаа харилцан ярилцах, цагийг өнгөрөөх талаар зөвлөн туслах;</p>
<b>Дасан зохицолт</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Нээлттэй, нөхөрсөг харилцах чадвар;</li> <li>- Багш, эцэг эхийн заавар зөвлөмжийг дагах чадвар;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх чадвартай.</li> <li>- Зан төлөвөө хянаж удирдах чадвартай ч зарим тохиолдолд гадаад орчны нөлөөлөлд хялбархан орох нь бий.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бие даасан зан төлөвийг нь дэмжих, бие даан асуудлыг шийдвэрлэх боломж олгох, хүсэл эрмэлзлэлийнх нь талаар ярилцах;</li> </ul>
<b>Үнэт зүйл</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>

<ul style="list-style-type: none"> <li>- Бусад хүмүүст хүндэтгэлтэй хандах чадвар;</li> <li>- Шударга харилцааг эрхэмлэх чадвар;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бусад насны бүлгийг бодвол өөртөө төвлөрч бусдад хүндэтгэлтэй хандах байдал өмнөх наснаас бага зэрэг буурч болно.</li> <li>- Харилцаанд эн тэнцүү байх, найз нөхөдтэйгөө санал солилцож тэдний байр суурин дээр өөрийгөө тавих, шударга бус харилцааг мэдэрч энэ талаар санаа бодлоо илэрхийлдэг байна.</li> </ul>	<p>Бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч дасан зохицох чадвар, бие даан зан төлөвөө зохицуулах, шийдвэр гаргах чадварыг сургууль, ангийн түвшинд, гэр бүлийн хүрээнд дэмжих;</p>
<b>Хэм хэмжээг дагах</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Дүрэм журмыг баримтлах чадвар;</li> <li>- Ёс зүйг баримтлах чадвар;</li> </ul>	<p>Олон нийтийн газар биеэ авч явах хэм хэмжээ, дүрэм журмын талаар сайн ойлгодог, баримтлах чадвартай.</p>	<p>Олон нийт, сургууль, гэр бүлийн орчинд тогтсон хэм хэмжээг баримтлах чадварыг дэмжих;</p>

## IV. Бүрэн дунд боловсролын 15-17 настай хүүхдийн хөгжлийн шалгуур

### *Хөгжлийн ерөнхий онцлог*

**Бие бялдрын хөгжил:** Биеийн өндөр, жин, булчингийн хүч нэмэгддэг, ялангуяа хөвгүүдийн өндөр илэрхий нэмэгдэнэ. Сэлэх, богино болон холлын зайд гүйх чадвар нэмэгдэнэ.

**Танин мэдэхүйн хөгжил:** Хийсвэр сэтгэхүй хөгжил танин мэдэхүйн үйлд давамгайлж, аливаа зүйлсийг хийсвэрлэн ойлгох, оюун дүгнэлт гаргах, үр дагаварыг нь урьдчилан таамаглах чадвартай болно.

**Нийгэмшлийн онцлог:** Ирээдүйн мэргэжил сонголт, амьдралын хэв маягийн талаар бодож төлөвлөдөг, мэргэжил сонголтондоо авьяас чадвар, сонирхол гэх мэтийг харгалзан үздэг. Сонирхол нь гүнзгийрч нийгэм, эдийн засаг, ёс суртахуун, соёл урлаг гэх мэт өргөн хүрэгэ хамарна. Харилцаанд нь үе тэнгийнхэн чухал байр суурьтай хэвээр байна. Эсрэг хүйстэнтэй харилцах нөхөрлөх хүсэл эрмэлзлэлтэй болно. Бие даан асуудлыг шийдвэрлэх хүсэл эрмэлзэл нэмэгдэж, шийдвэрлэх чадвартай болно.

### Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдрын хөгжил (15-17 нас)

#### Бие бялдрын хөгжил

<b>Биеийн жин (кг)</b>						
Биеийн жингийн дундаж үзүүлэлт нас нэмэгдэх тусам охидын хувьд 1.38- 1.35 кг аар, хөвгүүдийн хувьд 2.29-2.1 кг аар нэмэгддэг байна. Охидын биеийн жин 15 -17 насанд тогтворжиж, хөвгүүдийн биеийн жин жилд 1-2 кг нэмэгддэг.						
Түвшин	15 нас	16 нас	17 нас	15 нас	16 нас	17 нас
	Хөвгүүд			Охид		
Дээд	76.37	77.33	80.53	61.76	67.57	72.45
Дунджаас дээгүүр	60.07	63.07	66.28	55.56	57.86	60.56
Дундаж	54.92	58.3	61.04	52.50	53.82	55.36
Дунджаас доогуур	51.24	54.57	57.17	48.99	50.56	50.77



Доод	44.89	49.71	51.27	43.86	44.85	44.86
------	-------	-------	-------	-------	-------	-------

### Биеийн өндөр (см)

Охидын өндрийн өсөлт 15 -16 насанд 1 см нэгдэж байхад, хөвгүүдийн өндөр 3.6 - 4.6 см нэмэгдэнэ, харин охидын биеийн өсөлт хөгжилтийн процесс 16 наснаас, хөвгүүдийн биеийн өсөлт хөгжил 17 - 18 наснаас эхлэн удаахрах бөгөөд өндрийн өсөлт, ясжилтын процесс 17 -18 насанд үндсэндээ дуусдаг байна.

Түвшин	15 нас	16 нас	17 нас	15 нас	16 нас	17 нас
	Хөвгүүд			Охид		
Дээд	177.19	178.38	181.82	165.04	168.45	169.53
Дунджаас дээгүүр	171.73	173.32	174.73	160.80	161.78	162.29
Дундаж	167.76	170.22	171.48	157.81	158.43	158.99
Дунджаас доогуур	164.01	166.84	168.06	154.82	155.13	155.84
Доод	157.21	160.51	161.73	149.75	150.93	151.58

### Цээжний тойрог (см)

Хөвгүүдийн цээжний тойрог 15-16 насанд 1.41 см, 16-17 насанд 1.98 см-ээр нэмэгдсэн байна.

Түвшин	15 нас	16 нас	17 нас	15 нас	16 нас	17 нас
	Хөвгүүд			Охид		
Дээд	95.34	94.77	98.72	87.08	90.03	93.92
Дунджаас дээгүүр	85.92	87.15	90.03	83.39	85.08	86.65
Дундаж	81.87	84.44	86.68	81.23	81.87	83.03
Дунджаас доогуур	77.89	81.92	83.56	78.16	78.93	80.02

### Бүсэлхийн тойрог (см)

Хөвгүүдийн цээжний тойрог 1.4 см-ээр, 15 насны охидын хувьд бүсэлхийн тойрог 1.76см, бүсэлхийн тойрог 1.74 см -ээр нэмэгддэг байна.

Түвшин	15 нас	16 нас	17 нас	15 нас	16 нас	17 нас
	Хөвгүүд			Охид		
Дээд	85.07	82.76	85.11	74.93	77.96	82.34
Дунджаас дээгүүр	71.78	73.26	74.79	69.81	71.39	73.81
Дундаж	67.96	70.43	71.56	67.11	68.17	69.24
Дунджаас доогуур	65.7	68.08	68.88	64.45	65.23	65.42
Доод	61.98	63.58	64.04	59.81	60.88	61.09

### Бие бялдрын бэлтгэлжилт

**Хөдөлгөөний эвсэл: 3x10 м гүйлт (сек)** (10 м зурвасын хооронд 3 удаа гүйсэн хугацааг хэмжинэ. Сурагч бүр 2 удаа гүйх ба аль сайн үзүүлэлтийг тооцно.

Орон зайд биеэ хурдтай эргүүлж чиглэлээ өөрчлөн гүйх хөдөлгөөний эвслийн үзүүлэлт бөгөөд энэ нь хүүхдүүдийн хурдны үзүүлэлтээс хамааралтай байна. Охидын авхаалж самбаатай чанарын дундаж үзүүлэлт 9.13-9.35 сек байгаа нь жигд тогтвортой байгааг илэрхийлж байна. Хөвгүүдийн энэ үзүүлэлтэд 15 насанд өөрчлөлт ажиглагдаагүй ба 16 насанд 0.3 сек ахицтай байсан боловч 17 насанд 0.1 сек удааширсан байна.

Түвшин	15 нас	16 нас	17 нас	15 нас	16 нас	17 нас
	Хөвгүүд			Охид		
Дээд	7.20	7.09	6.95	8.41	8.18	7.99
Дунджаас дээгүүр	7.76	7.59	7.46	8.90	8.85	8.67
Дундаж	8.11	7.99	7.86	9.26	9.21	9.15
Дунджаас доогуур	8.59	8.44	8.34	9.73	9.68	9.76

Доод	9.55	9.72	10.38	11.02	10.28	12.23
------	------	------	-------	-------	-------	-------

### Зүүн гарын атгах хүч (кг)

Ахлах ангийн 15 - 17 насны хөвгүүдийн баруун, зүүн гарын атгах хүч 2-4 кг зөрүүтэй байна. 15 - 17 насны охидын зүүн гарын атгах хүч 2 кг зөрүүтэй байна.

Түвшин	15 нас	16 нас	17 нас	15 нас	16 нас	17 нас
	Хөвгүүд			Охид		
Дээд	44.24	45.56	48.18	28.68	30.86	32.09
Дунджаас дээгүүр	34.64	39.43	40.3	24.34	26.57	26.65
Дундаж	30.29	35.25	37.17	21.53	22.28	22.75
Дунджаас доогуур	26.94	30.44	31.22	19.44	20.24	20.21
Доод	20.59	21.11	25.15	12.28	15.82	15.48

### Баруун гарын атгах хүч (кг)

Охидын гарын атгах хүчний үзүүлэлт 16- 17 насанд тогтвортой байхад хөвгүүдийн гарын атгах хүчний үзүүлэлт нас нэмэгдэх тусам 2.67-1.58 кг аар нэмэгдсэн байна.

Түвшин	15 нас	16 нас	17 нас	15 нас	16 нас	17 нас
	Хөвгүүд			Охид		
Дээд	48.37	50.28	52.81	30.66	34.68	36.88
Дунджаас дээгүүр	39.31	42.62	44.71	26.29	28.41	29.35
Дундаж	33.49	39.36	39.85	23.06	24.23	25.39
Дунджаас доогуур	29.45	33.95	35.53	20.43	21.55	21.01
Доод	22.08	24.79	26.47	13.59	17.17	16.63

### Гарын хүч: Гар дээр суниалт (удаа) (Тулж хэвтсэн байдлаас 30 сек гар дээрээ суниалтын тоог тоолно.)

Хүүхдийн нас нэмэгдэх тусам гарын хүч нэмэгдэж байна. Хөвгүүд нас нэмэгдэх тусам 1-3 - удаа илүү суниаж байна.

Түвшин	15 нас	16 нас	17 нас	15 нас	16 нас	17 нас
	Хөвгүүд			Охид		
Дээд	36.29	38.92	42.48	22.78	24.26	29.53
Дунджаас дээгүүр	28.49	31.12	33.38	16.86	16.34	19.93
Дундаж	23.78	26.68	27.41	12.55	13.09	14.48
Дунджаас доогуур	18.66	20.94	22.09	9.21	8.81	9.64
Доод	10.63	12.48	10.92	2.87	3.83	3.58

### Уян хатан: бөхийлт (см) (Хөлөө жийж суусан байдлаас бөхийж, гарын хурууг өлмийнөөс цааш гаргасан зайг хэмжинэ)

Ахлах ангийн охидын уян хатны үзүүлэлт хөвгүүдээс илүү үзүүлэлттэй байна.

Түвшин	15 нас	16 нас	17 нас	15 нас	16 нас	17 нас
	Хөвгүүд			Охид		
Дээд	19.86	20.91	22.4	20.23	20.87	23.43
Дунджаас дээгүүр	13.66	15.85	15.85	14.53	14.85	17.31
Дундаж	9.45	11.03	9.79	11.09	11.56	13.93
Дунджаас доогуур	5.07	7.02	5.34	6.29	7.58	9.87
Доод	-3.15	-0.65	-1.72	-0.43	0.38	<b>1.83</b>

**Хөлийн хүч: байрнаас уртад харайлт (см) Байрнаас хоёр хөлөөр түлхэн уртад харайсан зайг хэмжинэ. 3 удаагийн харайлтын хамгийн холыг тооцно.**

Уян хатны чадавх нас нэмэгдэхийн хэрээр буурах магадлалтай байдаг. Хөвгүүдийн хувьд энэ үзүүлэлт нас тутамд дунджаар 14.48-3.13 см ээр нэмэгдсэн байна. Бөхийлтийн дасгалын дунджаас доогуур ба доод үзүүлэлт буурсан байгааг анхаарч, эдгээр түвшинг дээшлүүлэх шаардлагатай байна.

Түвшин	15 нас	16 нас	17 нас	15 нас	16 нас	17 нас
	Хөвгүүд			Охид		
Дээд	234.31	238.93	247.7	173.05	181.82	184.18
Дунджаас дээгүүр	210.69	223.78	227.66	158.53	161.44	165.53
Дундаж	197.58	213.06	216.08	147.32	149.32	151.67
Дунджаас доогуур	184.09	198.57	201.7	136.17	135.88	141.03
Доод	158.95	171.67	175.71	118.06	104.8	116.81

**Бие бялдрын чадварыг дэмжих үйл**

- Фитнесийн хэрэгсэлтэй дасгал хийж сургах
- Аэробэкээр аль болох хичээллдэг байх. Хэрэв хичээллэдэггүй бол энэ төрлийн холбогдох дасгалуудыг эцэг эх асран хамгаалагчид цахим орчноос болон биеийн тамирын багшаас суралцах хүүхдүүдийг дэмжих. Мөн биеийн тамирын багш нар ээлжит хичээл бүрээр аэробэкийн зарим нэг дасгалуудыг бие халаалтын үед аль болох хийлгэх.
- Байг оновчтой онох чадвартай болгох
- Буухиа тэмцээний төрөл бүрийн дасгал хөдөлгөөний чадвартай болгох
- 1000-1500 м-ийн зайд гүйх чадвартай болгох. Холын зайд энэ насны хүүхдүүдийн гүйх гадаад нөхцөл тааруу орчинд энэ чадварыг хэрхэн дэмжихийг биеийн тамирын багш нар тодорхой болгох хэрэгтэй. Улмаар улирал тутам холын зайн гүйлтийг хэрхэн дэмжихийг сургуулийн холбогдох хүмүүстэй зөвлөж хичээлийн жилийн эхэнд тодорхой болгох шаардлагатай. Хүүхдийн тэсвэр тэвчээрийн чадвар нь бие бялдрын хөгжлийн бусад бусад чадваруудын хөгжилд чухал болохыг эцэг эхчүүд асран хамгаалагчдад таниулахад багш нар санаачлагатай ажиллах хэрэгтэй.
- Төрөл бүрийн спортын уралдаан тэмцээнд аль болох оролцуулж, хүүхэд өөрийгээ сорих нөхцөлийг бүрдүүлээрэй.
- 22-23 цагийн хооронд тогтмол унтах хэвшилд сургах.

**Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил (15-17 нас)**

Хүртэхүй		
Шалгуур	Үзүүлэлт	Чадварыг дэмжих үйл
<b>Ажиглан хүртэх чадвар</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Юмсыг бүтэц бүрэлдэхүүнд нь ажиглан хүртэх чадвартай байх</li> <li>- Юмсын хэмжээ, хэлбэрийг болон тогтолцоонд нь хүртэх чадвартай.</li> <li>- Юмсыг учир шалтгаанд нь хүртэх нь хүчин чармайлт шаардах нь бий.</li> </ul>	Үзэгдэл юмсыг анхааралтайгаар учир шалтгаан зүй тогтолд нь ажиглан хүртэх чадварыг нь дэмжих;
Анхаарал		
Шалгуур	Үзүүлэлт	Чадварыг дэмжих үйл

<p><b>Анхаарлаа төвлөрүүлэх чадвар</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хийсвэр сэтгэхүйн хөгжилтэй холбоотой анхаарлаа төвлөрүүлэн бүтээлчээр ажиллах чадвар нэмэгдэх.</li> <li>- Нэмэх, хасах, хуваах гэх мэт үйлдэл, үгэн хэлбэрийн дэс дараалалтай нарийн үйлдэлтэй даалгаврыг зориудаар анхаарлаа төвлөрүүлэн гүйцэтгэх чадвартай.</li> <li>- 1 минутад ойролцоогоор 36-37 хүртэлх энгийн дүрс тэмдэгт тэмдэглэх чадвартай. Хүчин чармайлт шаардсан үйлдэлд хялбар ядарч анхаарал нь суларч бүтээмж буурах хандлагатай.</li> </ul>	<p>Нэг төрлийн үйлээс өөр төрлийн үйлд анхаарлаа төвлөрүүлэн ажиллах чадварыг дэмжих; Анхаарлаа төвлөрүүлэн хурдтай ажиллах чадварыг дэмжих;</p>
<b>Ой тогтоолт</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<b>Мэдээллийг тогтоох чадвар</b>	<p><i>Богино хугацаанд хараад тогтоох:</i> Хийсвэр сэтгэхүйн хөгжилтэй холбоотой хийсвэр мэдээллийг харж тогтоох чадвар сайжрах Богино хугацаанд энгийн дүрс, тэмдэгт, зургуудийг хараад 10-11-ийг тогтоож, сэргээн санана. Цифр/үг зэргийг хараад 6-7 хүртэлхийг тогтоож сэргээн санана.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хичээл дээр богино хугацаанд харж тогтоох дүрс тэмдэгтүүд нь 12—оос хэтрэхгүй байх;</li> <li>- Тогтоох үг/цифр зэрэг нь 8 хүртэлх байх;</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>- <i>Богино хугацаанд сонсоод тогтоох:</i> Хийсвэр сэтгэхүйн хөгжилтэй холбоотой хийсвэр мэдээллийг сонсоод тогтоох чадвар сайжрах</li> <li>- Богино хугацаанд зорилготойгоор 6-7 хүртэлх үгийг тогтоож сэргээн санах чадвартай.</li> </ul>	<p>Хичээл дээр сонсоод тогтоох үгийн тоо нь 8 хүртэлх байх ба аажмаар тоог нь нэмэгдүүлэх;</p>
	<p><i>Мэдээллийг утгаар нь тогтоох:</i> Хийсвэр сэтгэхүйн хөгжилтэй холбоотой утгачлан тогтоох чадвар сайжрах Нарийн үйл явдалтай болон танил бус, гадаад үг хэллэг үйл явдалтай эхийг утгаар нь тогтоохдоо 16-17 хүртэлх утгыг тогтоож сэргээн санах чадвартай.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Эхийг сонсож, уншуулж тогтоолгохдоо 18-19 хэллэг бүхий утгын нэгжээс хэтрэхгүй байх, аажмаар тоог нь нэмэгдүүлэх;</li> <li>- Тогтоосон зүйлээ бичих, ярих гэх мэт үйлийг тогтмол хийх;</li> </ul>
<b>Сэтгэхүй</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<b>Сэтгэхүйн ангилах, нэгтгэн дүгнэх чадвар</b>	<ul style="list-style-type: none"> <li>- <i>Сэтгэхүйн ангилах чадвар:</i> Юмсыг хэлбэр, дүрс, хэмжээ, эсвэл төрөл зүйл, дотоод мөн чанараар нь бүлэглэх чадвартай;</li> <li>- <i>Сэтгэхүйн харьцуулах чадвар:</i> Юмсыг эсрэг шинж, өнгө хэлбэр, дүрс, учир шалтгаан холбоо хамаарлаар нь харьцуулан ялгатай ба төстэй талыг таних чадвартай;</li> <li>- <i>Сэтгэхүйн нэгтгэх чадвар:</i> Үзэгдэл юмсыг гадаад шинж, хэрэглээ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үгийг төрөл, зүйл, утгаар нь бүлэглэх үйлдлийг хийх;</li> <li>- Хичээлийн агуулгыг холбоо хамаарлаар нь ангилах үйлдлийг хийх,</li> <li>- Үзэгдэл юмсыг ижил төстэй нийтлэг мөн чанараар нь нэгтгэн нэрлэх гэх мэт үйлдлийг хийх;</li> </ul>

	зориулалт, мөн чанар, зүй тогтлоор нь нэгтгэн илэрхийлэх чадвартай.	
<b>Математик сэтгэхүйн чадвар</b>	2 үйлдэл бүхий энгийн бодлогыг бодох чадвартай ба учир шалтгаанд нь сэтгэх олон үйлдэлт даалгаврыг гүйцэтгэхдээ бэрхшээх нь бий.	Учир шалтгаанд нь сэтгэх танин мэдэхүйн чадварыг бодит үйлдэл, дүрслэл дээр тулгуурлаж хийсвэр сэтгэхүйн хөгжлийг дэмжих;
<b>Хэл яриа</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<b>Үгийн утга тайлбарлах чадвар</b>	Бодит ахуйн үг, хийсвэр үгийн утгыг илэрхийлж буй юмсын үзүүлэх нөлөө, гадаад төрх байдлаар нь тайлбарлах хандлагатай, утгыг оновчтой тайлбарлах чадвар сайжирна. Салаа/ижил утгатай үгийн утгыг тэр бүр оновчтой тайлбарлахгүй байх нь ажиглагдаж болно;	<ul style="list-style-type: none"> <li>- Үг, шинжлэх ухааны нэр томъёог өөрийн ойлголтоор оновчтой тайлбарлах чадварыг дэмжих;</li> <li>- Салаа/ижил утгатай үг, тэмдэг нэрийн үгийн нөөцийн нэмэгдүүлэх;</li> </ul>
<b>Ярих чадвар</b>	Энгийн богино өгүүлбэрээр ерөнхийлөн дүгнэж ярих нь давамгай. 2-3 минутад санаа бодлоо зориудаар дунджаар 30-32 үгээр илэрхийлнэ.	Нийлмэл өгүүлбэрээр бодол санаагаа оновчтой, учир шалтгаанд нь илэрхийлэх чадварыг дэмжих;

### Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (15-17 нас)

<b>Өөртөө хандах хандлага</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- <b>Өөртөө итгэлтэй байх чадвар;</b></li> <li>- <b>Өөрийгөө эерэгээр үнэлэх чадвар;</b></li> <li>- <b>Өөрийгөө хүлээн зөвшөөрөх чадвар;</b></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Өмнөх настай харьцуулахад өөртөө итгэх итгэл нь бага зэрэг буурч болно, өөртөө шүүмжлэлтэй хандах чадвартай.</li> <li>- Өөрийгөө бодитоор үнэлж, хүлээн зөвшөөрөх чадвартай.</li> <li>- Давуу ба сул талуудаа мэддэг.</li> </ul>	Өөрийн тухай ойлголтыг түүний чадвар эерэг талыг мэдүүлэх замаар бодитоор дэмжих;
<b>Зан төлөв</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- <b>Үйл ажиллагаанд оролцох чадвар;</b></li> <li>- <b>Нийцтэй харилцах чадвар;</b></li> <li>- <b>Сэтгэлийн түгшүүрээ удирдах чадвар;</b></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Биеэ дайчлан идэвх зүтгэл гаргах чадвартай.</li> <li>- Бусадтай нийцтэй зан төлөвтэй, хариуцлагаа ухамсарладаг.</li> <li>- Зан төлөвөө удирдан зохицуулах чадвартай.</li> <li>- Сэтгэл санааны хувьд ерөнхийдөө тогтвортой боловч заримдаа сэтгэл</li> </ul>	Нийтэч нөхөрсөг харилцах, алив асуудлыг хамтран хэлэлцэх, үүрэг хариуцлагатай бие даан хандах чадварыг нь дэмжих;

	<p>түгшүүр, айдас автагдах нь ажиглагдаж болно.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эмэгтэй хүүхдүүд эрэгтэй хүүхдүүдтэй харьцуулахад стресс, түгшүүрт илүү өртөмтгий, эмзэг байгаа нь ажиглагдаж болно.</li> </ul>	
<b>Сэтгэлийн хөдөлгөөн</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- <b>Сэтгэлийн хөдөлгөөнийг таних, зохицуулах чадвар;</b></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сэтгэлийн хөдөлгөөний илрэлээ сайн мэддэг, юунд таатай, таагүй ханддагаа мэддэг, илэрхийлж чадна.</li> <li>- Сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах чадвартай боловч сэтгэлийн хөдөлгөөндөө автагдах нь ажиглагдаж болно.</li> <li>- Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг таних чадвартай.</li> <li>- Хөвгүүд нөхцөл байдалд тохируулан сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх нь охидоос илүү байдал ажиглагдаж болно .</li> </ul>	<p>Сэтгэлийн хөдөлгөөнөө орчин нөхцөлд тохируулан хянаж удирдах чадварыг дэмжих;</p>
<b>Харилцаа</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- <b>Нийтэч, идэвхтэй байх чадвар;</b></li> <li>- <b>Баг, бүлгээр ажиллах, олон нийттэй харилцах чадвар;</b></li> <li>- <b>Бусдын сэтгэл санааг ойлгох чадвар;</b></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бусадтай харилцах, хамтрах чадвар сайн.</li> <li>- Бусдын сэтгэл санааны байдлыг ойлгож хуваалцах чадвартай.</li> <li>- Нээлттэй нөхөрсөг харилцаатай, бие дааж асуудалд хандах чадвартай.</li> </ul>	<p>Бие даасан хандлага, нөхөрсөг нээлттэй зан төлөвийг нь дэмжих;</p>
<b>Энэнгшилт</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<p><b>Эцэг эх, асран хамгаалагчаа ойлгож дотно харилцах чадвар</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг эхтэйгээ ойр дотно харилцдаг, тэдэнд итгэх итгэл сайн;</li> <li>- Эцэг эхээсээ тусдаа байх чадвартай эцэг эх, асран хамгаалагчаасаа тусдаа бие даах чадвартай.</li> </ul>	<p>Ээж аавтайгаа нөхөрсөг нээлттэй харилцах чадварыг нь дэмжих;</p>
<b>Дасан зохицолт</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- <b>Өөрийн зан төлөвөө зохицуулах чадвар;</b></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бусдын ялгаатай байдал, зан төлөвийг хүлээн зөвшөөрч, эрх тэгш харилцах чадвартай.</li> </ul>	<p>Бие даан асуудлыг шийдвэрлэх боломж олгох,</p>

<p>- <b>Бусдын үзэл бодол, үйлдлийг хүлээн зөвшөөрөх чадвар;</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Бие даан шийдвэр гаргах чадвартай ч заримдаа орчин тойрны хүмүүсийн нөлөөнд орох хандлага ажиглагдах боломжтой.</li> <li>- Бие даан зан үйлээ зохицуулах чадвартай.</li> <li>- Бусдын санаа бодол хүсэл эрмэлзлэлийг зан үйлдээ харгалзан үздэг.</li> </ul>	<p>хүсэл эрмэлзлэлийнх нь талаар ярилцах;</p>
<b>Үнэт зүйл</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<p><b>Үнэт зүйлийн тогтолцоотой байх;</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл аюулгүй орчинд амьдрах, бусдыг хүндлэх энэрч хайрлах, бусдад тэгш шударга хандах, үндэсний уламжлал ёс заншил зэргийг маш чухал гэж үздэг.</li> <li>- Бусадтай нийцтэй нөхөрсөг харилцах, бусдын амжилтад талархах, бие даасан байх, зугаацан баярлах зэргийг амьдралд чухал хэмээн үздэг.</li> </ul>	<p>Бусдын зүгээс хүндэтгэл, сайн хандлага хүлээх нь чухал гэсэн хандлагыг нь сайжруулах;</p>
<b>Нийгмийн хэм хэмжээ</b>		
<b>Шалгуур</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чадварыг дэмжих үйл</b>
<p><b>Дүрэм журмыг дагах чадвар; Ёс зүйг баримтлах чадвар;</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Сургууль, олон нийтийн орчинд хэв журмыг баримталж, багш ахмад хүмүүсийн заавар, дүрмийг биелүүлнэ.</li> <li>- Олон нийтийн газар биеэ авч явах, бусдыг хүндэтгэж, нийцтэй харилцана.</li> <li>- Охид ёс суртахууны хэм хэмжээ, дүрэм журам, олон нийтийн газар биеэ авч явахад эрэгтэй хүүхдүүдээс илүү ач холбогдол өгөх нь ажиглагдаж болно.</li> </ul>	<p>Хэм хэмжээ, дүрмийг баримтлах чадварыг нь сургууль гэр бүл, олон нийтийн орчинд дэмжих;</p>